

4.5. НИЙГМИЙН УХААН

4.5.1. Түүх, нийгмийн ухааны судлагдахууны интеграц

Нийгэм, эдийн засгийн хөгжил нь хүмүүсийн амьдрах орон гэр болсон байгальтай зохицсон байх нь хүн бүхнээс ухаалаг, зөв хэрэглээ, өндөр ёс зүй, төлөвшил, хариуцлагатай шийдвэр гаргах мэдлэг, чадвар, үнэт зүйлсийг шаардах боллоо. Үүний зэрэгцээ байгаль орчны доройтол нь хүмүүст эх дэлхий, байгаль орчинтойгоо зохицон, амьдралын чанараа хадгалан хөгжих хэрэгцээг буй болгож байна. Энэхүү хэрэгцээг хангаж, хүүхэд залуусыг ухаалаг, хариуцлагатай хэрэглээнд суралцахад ерөнхий боловсролын түвшинд судалж буй түүх, нийгмийн ухааны хичээл онцгой хувь нэмэр болно. Тухайлбал, "... бүх нийтээр хүний эрх, нэр төр, арьс өнгө, үндэстэн, үүсэл гарал, соёлын олон янз байдлыг хүндэтгэдэг, хууль, шударга ёс, тэгш эрх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг дээдэлдэг дэлхий ертөнц"-ийг¹¹⁹ бүтээгч иргэдийг хөгжүүлж, төлөвшүүлэхэд нийгмийн ухааны хичээлийн агуулга шууд хамаарна. Мөн "...өнөөгийн бидний дэлхий ертөнцөд тулгараад буй байгалийн доройтол сорил, бэрхшээлийг"¹²⁰ шийдэхэд түүхийн хичээлээр судалж буй нүүдлийн соёл иргэншлийн үнэт зүйл, байгальтай харилцах монгол арга ухаан тодорхой шийдэл болох юм.

Түүх, нийгмийн ухааны хичээл нь ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөнд 6-11 дүгээр ангид хичээлийн жилийн туршид 35-70 цаг заавал судлахаар тусгагдсан. Мөн ахлах ангид заавал судлах хөтөлбөрөөс гадна "Шударга ёс", "Монголын нийгэм", "Нүүдлийн иргэншил", "Монголчуудын өв соёл" гэх мэт агуулгын хүрээнд сонгон судлах хөтөлбөрөөр хичээллэж байна.

Түүх, нийгмийн ухааны (ТНУ) суурь боловсрол, нийгмийн ухааны бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн зорилго нь "Сурагчийг түүх, нийгмийн үйл явдал, үзэгдэл, нийгмийн бодит байдал, үйлдэл, үйл ажиллагааг танин мэдэх, шинжлэх ухаанчаар судлах арга барилтай, үндэсний бахархал, соёл уламжлалаа дээдлэн өвлөж, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг хүндэтгэдэг, нийгмийн үнэт зүйлсийг эрхэмлэн хэрэгжүүлдэг, оролцоотой, хариуцлагатай, бүтээлч, бие дааж шийдвэр гаргах чадвартай иргэн болж төлөвших"¹²¹-д хувь нэмэр оруулах явдал бөгөөд энэхүү зорилгыг хэрэгжүүлснээр ТХБ-ийн суралцахуйн зорилтыг хангаж, сурагчийн тогтвортой хөгжих цогц чадамжийг хөгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулах боломжтой байна. Тухайлбал¹²²,

- Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөрийн дагуу сурагчид "Хувь ба нийгэм", "Хувь хүн ба соёл" "Хувь хүн ба эдийн засаг" "Хүний эрх ба хууль", "Нийтийн удирдлага", "Нийгэм, нийгмийн харилцаа", "Эдийн засаг", "Хүний эрх", "Олон улсын харилцаа" зэрэг үндсэн агуулгын хүрээнд эдийн засгийн зохистой хэрэглээ, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, үүрэг хариуцлага, эрх зүйт ёс, хүнлэг

119 НҮБ-ын ЕА Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр., Бидний алсын хараа., <http://www.un-mongolia.mn/new/wp-content/uploads/2012/10/SDGs-Resolution-adopted-by-UN-GA-Mongolian-Version.pdf>

120 Мөн тэнд., Өнөөгийн бидний дэлхий ертөнц

121 БСШУ-ны сайдын тушаал А/302., 2016.07.10, БСШУ-ны сайдын тушаал А/277, 2016.06.27

122 ТХЗ болон ТХ-ийн суралцахуйн зорилтод хамаарах хэсгийг Italic-аар тэмдэглэв.

ёс, ардчилал, энх тайван зэрэг нийгмийн үнэт зүйлсийг судалж, өөрийнмшүүлж байдаг.

- Сурагчид дээрх агуулга, нийгмийн бодит байдал, хүмүүсийн үйлдэл, үйл ажиллагааг жишээ, тохиолдол, онолын мэдээлэл, судалгааны материал бусад эх сурвалжид тулгуурлан асуудал дэвшүүлэн шийдвэрлэх, асуудлыг эдийн засаг, улс төр судлал, соёл судлал зэрэг нийгмийн шинжлэх ухааны салбар хоорондын хандлагаар авч үзэх, өөрийгөө таньж мэдэх, асуудалд шүүмжлэлтэй хандах, урьдчилан тооцоолох, хамтран ажиллах, нийгмийн аливаа үзэгдлийг цогц уялдаа холбоонд судлах, нотолгоо, үндэслэгээнд тулгуурлан дүгнэлт хийх зэрэг ур чадвар, арга барилаа хөгжүүлнэ.
- "Шударга ёс" хам агуулгаар (контекст) нийгмийн амьдралын хүрээнд тулгамдаж буй асуудлыг шударга ёсны шалгуурын үүднээс дэвшүүлж, шийдлүүдийг санал болгох замаар бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлж, шударга ёсны үнэлэмжийг өөрийнмшүүлэх, нийгмийн ухааны салбар хоорондын хандлагаар аливаа асуудлын учир шалтгаан, үр дагаврыг судлан, дүгнэлт, шийдлийг дэвшүүлэх, бие даан суралцах арга барил, амьдрах ухаанд суралцахад чиглэсэн байна.

Агуулгын интеграцыг тодорхойлсон байдал

Бид суурь боловсролын түүх, нийгмийн ухаан, бүрэн дунд боловсролын нийгмийн ухааны боловсролын сургалтын хөтөлбөрийн¹²³ агуулга (суралцахуйн зорилт) болон ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, ТХЗ-д хүргэх санал болгож буй сэдэв бүрийг харьцуулан тэдгээр нь суралцахуйн зорилт, сэдэв, цогц чадамжтай агуулга, үзэл санаа, эзэмшүүлэх чадвараараа нийцэж байгааг шинжлэх замаар ТХБ-ыг ТНУ-ны хичээлд интеграцчилах боломжийг тодорхойлохыг хичээв. Тухайлбал,

- Суурь боловсролын Түүхийн сургалтын хөтөлбөрийн "9, 2.4.б.¹²⁴ Дэлхийн 2 дугаар дайн, хүйтэн дайн зэрэг дэлхийн түүхийн үйл явдлыг тухайн үеийн Монгол улсынхаа түүхтэй холбон судална" гэсэн агуулга нь ТХ-ийн "Энхтайван, шударга ёс, хүчирхэг институт"-ын талаарх 16 дугаар зорилгын хүрээнд тодорхойлсон "Сурагч орон нутаг, дэлхий нийтийн түвшний энх тайван, шударга ёс, тусгай эрэлт хэрэгцээг хангасан байдал болон хүчирхэг институцэд хамаарах асуудлаар мэтгэлцэж чаддаг болох" суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх боломжтой байна.
- Учир нь тухайн агуулгын хүрээнд дэлхийн II дайны болон социалист, капиталист хоёр лагерын хооронд өрнөсөн хүйтэн дайны шалтгаан, үйл явц, тэдгээрийн үр дагавар, төгсгөл зэргийг түүхэн талаас нь судлахдаа сурагчид зайлшгүй энхтайван байдал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөөтэй холбон авч

123 БСШУ-ны сайдын тушаал А/302., 2016.07.10, нэгдүгээр хавсралт., БСШУ-ны сайдын тушаал А/277, 2016.06.27

124 ТХЗ, ТХБ болон ТНУ-ны сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоог шинжлэхдээ сургалтын хөтөлбөрийн агуулгыг кодлон тэмдэглэсэн болно. Тухайлбал, "9, 2.4.б" гэдэг нь суурь боловсролын түүхийн сургалтын хөтөлбөрийн "Анги бүрийн агуулга" хэсгийн 9 дүгээр ангийн "Монгол ба орчин үеийн дэлхий дахин: 1911 оноос өнөө үе" хэсгийн 4. Социализмын үеийн Монгол улс ба дэлхий дахин (1924-1990) агуулгын 2 дахь хэсэг буюу "Дэлхийн 2 дугаар дайн, хүйтэн дайн зэрэг дэлхийн түүхийн үйл явдлыг тухайн үеийн Монгол улсынхаа түүхтэй холбон судална" гэсэн агуулгыг кодолсон хэрэг болно. (БСШУ-н, Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр., гарын авлага., 2015., 81-82 тал)

үздэг. Мөн дэлхийн II дайны үед еврей нарыг хоморголон устгасан, залхаан цээрлүүлсэн түүх ч хүн төрөлхтөн шударга ёс, тэгш байдал, ялгаварлан гадуурхлаас ангид байх ёстойг сануулдаг.

- Дайны түүхийн хүрээнд улс орны төр засгийн бодлого болон олон улсын түвшний хүчирхэг институт болох НҮБ-ын үүх түүх, үүрэг зориулалтыг ТХ-ийн 16 дугаар зорилготой холбон судлах боломжтой юм.

Дээрх агуулга нь “ТХ316.Сэ01” буюу “Шударга ёсны тодорхойлолт, залхаан цээрлүүлэлт...” сэдэвтэй тохирч байна гэх зэргээр уялдуулан шинжиллээ. Нийгмийн ухааны хичээлийн зарим агуулга ТХ3-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга, ТХ-ийн зарим зорилготой шууд давхцаж байна. Тухайлбал, YII ангийн “Хувь хүн ба эдийн засаг” агуулгын хүрээнд “өрх гэр бүлийнхээ хэрэгцээ орлого, зарлагыг судалсны үндсэн дээр хэрэгцээ хязгааргүй, нөөц баялаг нь хязгаарлагдмал шинжтэй болохыг ойлгон, ухаалаг хэрэглээнд суралцана” гэсэн зорилт тавьсан нь ТХ-ийн 7, 8, 12 дугаар зорилготой холбогдож байна.

Хүснэгт 4.5.1. Нийгмийн ухааны сургалтын цөм хөтөлбөрийн ТХ3-д хамаарах суралцахуйн зорилт

ТНУ-ны сургалтын хөтөлбөр	Тогтвортой хөгжлийн зорилт																	Нийт		
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17			
Суурь	Түүх		2	1	1	1			1	1	1	1				1	2		12	
	Нийгэм судлал	1			2	1	1	1	4		1	1	1						1	14
БДБ	Нийгэм судлал	1		1	1	1			3	1	1		2					4	2	17

Шинжилгээг хийхдээ дараах шаардлагыг баримталсан болно. Үүнд:

- ТХ3-д хамаарах суралцахуйн зорилт, сэдэвтэй ТНУ-ны сургалтын хөтөлбөр, түүний агуулга, суралцахуйн зорилт нь шууд болон дам байдлаар холбогдохуйц байх;
- Интеграцыг хэрэгжүүлэхэд ТНУ-ны сургалтын хөтөлбөрийн агуулга алдагдахгүй байх өөрөөр хэлбэл, хичээлийн үндсэн агуулгын хүрээнд хэрэгжих боломжтой байх;
- Багшид ТНУ-ны хичээлийг ТХБ-д интеграцчилахад санаа авахуйц, тодорхой байх;

Бид дээрх шаардлагын хүрээнд ТХ3-д хамаарах суралцахуйн зорилт, санал болгож буй сэдэвт ТНУ-ны сургалтын хөтөлбөрийн агуулгыг уялдуулан сонгосон. Энэ нь зөвхөн бидний сонгосон агуулгаар хязгаарлагдаж, тэр хүрээнд л сурагчдад ТХБ олгоно гэсэн үг биш юм. Бид агуулгыг сонгохдоо багш та бүхнийг сурагчиддаа ТХБ олгох, тэдний тогтвортой ажиллаж, амьдрахад шаардлагатай цогц чадамжийг хөгжүүлэхэд санаа авахад хэрэг болох талыг илүү харгалзсан болно. Багш та бүхэн үүнийг хөгжүүлэн, боловсронгуй болгож, зөвхөн ТНУ-ны хичээлээр хязгаарлалгүй хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар сурагчдынхаа ТХБ-ыг дэмжих нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, түүх, нийгмийн ухааны дэд багийн гишүүд ТХ3, ТХБ болон ТНУ-ны сургалтын цөм хөтөлбөрийн уялдаа холбоог шинжилж, юуны өмнө багшийн хувьд

хэрэгжүүлэх боломжтой, интеграцчилал хийхэд дөхөмтэй суралцахуйн зорилтуудыг гаргахыг хичээсэн болно.

Бид ТХ3-д хамаарах, танин мэдэхүй, нийгэм сэтгэл хөдлөл, зан үйлийн айн хүрээнд тодорхойлсон суралцахуйн зорилтуудыг дараах байдлаар ойлгож, уялдаа холбоог нь авч үзлээ. Үүнд:

- Танин мэдэх нь ихэнхдээ үргэлжилсэн нөхцөл байдал ба өөрчлөлтийн цогц уялдаа холбоонд шүүмжит анализ хийхэд чиглэнэ. Тухайлбал, ТНУ-ны хичээлээр сурагчид өнгөрсөн үед болсон, өнөө үед болж буй нийгмийн олон талт үзэгдэл, үйл явдлыг хувь хүний, орон нутаг, бүс нутгийн, олон улсын нөхцөл, уялдаа холбоо дунд судалж танин мэдэхүйгээ хөгжүүлж байдаг. Ингэхдээ тэд түүхийн болон өнөөгийн нийгмийн олон янзын эх сурвалжийг судлах, бусад хичээлтэй уялдаатай хэрэгслүүдийг (түүхэн газрын зураг, статистик мэдээ, график зураг, тоо, ном зохиол) ашиглах явцад олж авсан ур чадвараа ашигладаг.
- Нийгэмшил-сэтгэл хөдлөлийн суралцахуйн зорилт нь хүн төрөлхтний амьдрах орчин, соёлын үнэ цэн, олон янзын зарчим, хүмүүсийн хүлээн авах хандлага адилгүй байдаг гэдгийг ойлгосноор хангагдана. Үүнийг ухаарах нь зөвхөн мэдлэг олох бус, өөрийн үзэл бодлыг өөрчлөх хүсэл, бусдын оронд өөрийг тавихад бэлэн байхыг бас хэлнэ. Түүхэн болон дэлхийн түвшинд үнэлэлт дүгнэлт хийнэ гэдэг нь хувь хүн, урлаг соёл, норматив хэм хэмжээний олон талт хүчин зүйлсийг ойлгох, хүндэтгэх бэлэн байдал/хүсэл юм.
- Зан үйлийн суралцахуйн зорилт нь тухайлбал, нийгмийн ухааны болон түүхийн хичээлээр эзэмшсэн тодорхой ур чадвар дээрээ суурилан арга хэмжээ авна гэсэн үг юм. Хүн төрөлхтний туулж өнгөрсөн түүхээс сургамж авч, түүхээ мэддэг болсон хүний хувьд одоо болон ирээдүйд тулгарах бэрхшээлд бэлэн байж, хариу үйлдэл үзүүлэх нь зан үйлийн хувьд сурагчдад гарч буй өөрчлөлт юм. Сурагч өөрийн амьдралыг идэвхтэйгээр авч явах, тогтвортой хөгжих, хамтдаа зөрчлийг шийдвэрлэх стратеги боловсруулахад хувь нэмрээ оруулах, дайснах болон хүнийг ялгаварлах үзлээс ангижрах, байгалийн баялгийг үгүй хийхийн эсрэг өөрийн хувь нэмрээ оруулж байвал энэ нь ТНУ-ны болон ТХ3-д хамаарах зан үйлийн суралцахуйн зорилтыг хэрэгжүүлж байна гэсэн үг юм.

Хүснэгт 4.5.2. ТНУ-ны хичээлээр хэрэгжүүлж болох ТХ3-д хамаарах суралцахуйн зорилт

ТНУ-ны сургалтын цөм хөтөлбөр	ТХ3-д хамаарах суралцахуйн зорилт			Нийт	
	Танин мэдэхүйн	Нийгэмшил-сэтгэл хөдлөлийн	Зан үйлийн		
Суурь	Түүх	5	6	1	12
	Нийгэм судлал	5	5	4	14
БДБ	Нийгэм судлал	11	2	4	17

Шинжилгээнээс үзэхэд ТНУ-ны хичээлээр ТХБ-ын цогц чадамжийг сурагчдад эзэмшүүлэхэд дараах байдлаар хувь нэмэр оруулах боломжтой байна. Үүнд:

- Түүхийн хичээлийн хувьд ялангуяа, урьдчилан тооцоолох цогц чадамжийн төлөвшилд илүү хувь нэмэр оруулах боломжтой. Учир нь сурагчид түүхийг судлахдаа өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн хэлхээнд авч үзэх бөгөөд тухайн түүхэн үзэгдэл, үйл явдал бидэнд ямар сургамж үлдээсэн, түүхийн ямар алдааг давтахгүй байх талаар хэлэлцэх болдог.
- Үүний зэрэгцээ түүх судалж буй сурагч бүр өөрийн үнэт зүйлийг бүтээж, эзэмшиж байдаг; эрэгч, хайгч байдаг; системтэй арга, арга зүй эзэмшдэг; аливаад олон талаас нь, тэнцвэртэй хандах арга барилтай болдог; өөрийгөө бусдын оронд тавьж, бусдыг ойлгохыг хичээдэг зэргээрээ ТХБ-ын цогц чадамжийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг.
- Нийгмийн ухааны хичээлээр тогтолцоот болон шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх, хэм хэмжээний, хамтран ажиллах, өөрийгөө танин мэдэх цогц чадамжийг төлөвшүүлэхэд илүү хувь нэмэр оруулж чадна. Сурагчдад эдгээр цогц чадамжийг хөгжүүлснээр орон нутаг, улс үндэстэн цаашлаад дэлхий нийтийн ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр болох ач холбогдолтой юм.

Дүгнэж үзэхэд ЕБС-д судалж буй ТНУ-ны хичээлийн агуулга, арга зүй нь бүхэлдээ ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх, урьдчилан тооцоолох, тогтолцоот болон шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх, хэм хэмжээний, хамтран ажиллах, өөрийгөө танин мэдэх цогц чадамжийг төлөвшүүлэхэд илүү хувь нэмэр болно.

Хүснэгт 4.5.3. ТХБ-ын цогц чадамжийн төлөвшилд нийгмийн ухааны цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын оруулах хувь нэмэр

Судлагдахуун		Нийгэм судлал		Түүх	Нийт
		СБ	БДБ	СБ	
Боловсролын түвшин		СБ	БДБ	СБ	
ЦХ-ийн суралцахуйн зорилт		14	17	12	
ТБ-ын цогц чадамж	1. Тогтолцоот сэтгэлгээний	3	8	2	13
	2. Урьдчилан тооцоолох	3	1	5	9
	3. Хэм хэмжээний		3	1	4
	4. Стратегийн		3		3
	5. Хамтран ажиллах	2	3		5
	6. Шүүмжлэлт сэтгэлгээний	8	3	5	16
	7. Өөрийгөө таньж мэдэх	3	1	1	5
	8. Асуудал шийдвэрлэх нэгдсэн		1		1
Нийт (давхардсан)		19	23	14	56

Суурь боловсролын нийгмийн ухааны цөм сургалтын хөтөлбөрийн агуулга нь сурагчид орон нутгийн түвшний асуудлыг таних, мэдэх, ойлгох, асуудлыг шийдвэрлэхэд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх, хамтран ажиллахад чиглэдэг бөгөөд эдгээрийг орон нутгийн түвшинд тогтвортой хөгжлийн асуудалтай холбон үзэж болно. Тухайлбал, VIII ангийн “Хувь хүн ба эдийн засаг” агуулгын “Орон нутгийн

хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулах, идэвх санаачилгатай оролцох талаар шинэ санаа хувилбарыг дэвшүүлэхийн зэрэгцээ бусдыг уриалах, оролцуулахад нөлөөлөх чадварт суралцуулна” суралцахуйн зорилтыг тогтвортой хөгжлийн “Сурагч ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, өргөжүүлэн тэлэх чадвартай болох” (ТХ301.3Y1) гэсэн зорилт, “Хөгжлийн төлөөх хамтын ажиллагаа” (ТХ301.Сэ09) сэдэвтэй илүүтэй нийцнэ хэмээн үзлээ. Учир нь дээрх зорилтын хүрээнд сурагч өөрийн орон нутгийн түвшин дэх тогтвортой хөгжлийн асуудлыг хөндөх боломжтой бөгөөд тухайлбал, хүмүүсийн аж байдлыг судлан тусламж, дэмжлэг шаардлагатай ядуу айл өрх, хүмүүст туслах, ядуурлыг бууруулах, тэднийг ажилтай, орлоготой болгоход чиглэсэн ажлыг санаачилж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, хувийн хэвшлийнхэн, ард иргэдтэй хамтран хэрэгжүүлэх замаар орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулж болох юм. Ядуурлыг бууруулах асуудал нь дэлхийн нийтийн тогтвортой хөгжлийн эхний зорилт бөгөөд үүнийг багасгахад нэн түрүүнд айл өрх, орон нутгийн түвшин дэх ядуурлын асуудлыг авч үзэх нь чухал.

Мөн VII ангийн “Хувь хүн ба эдийн засаг” агуулгын “Сургуулийнхаа эдийн засгийн талаарх төсөөллөө өргөжүүлж сургалтын зардлын талаар мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийж тооцоолол хийх чадварт суралцаж зардлыг хэмнэх эрмэлзэлтэй болно” суралцахуйн зорилтыг тогтвортой хөгжлийн 17 дахь зорилгын “Сурагч тогтвортой хөгжлийн зорилгод хүрэхийн тулд өөриймсөг ханддаг болох” (ТХ317.НСХ3) гэсэн зорилт “Дэлхийн иргэншил ба тогтвортой хөгжлийн төлөөх өөрчлөлтийг бүтээгчид болох иргэд” (ТХ317.Сэ05.) сэдэвтэй уялдах боломжтой гэж үзэв. Учир нь тогтвортой хөгжлийн гурван тулгуур баганын нэг нь эдийн засгийн асуудал бөгөөд цөм хөтөлбөрийн дээрх зорилтыг хэрэгжүүлэхдээ сургуулийн эдийн засгийн асуудлыг тогтвортой хөгжилтэй холбон авч үзэх боломжтой. Тухайлбал, анги хамт олноороо хамтран сургуулийн ус болон цахилгааны зардлыг тооцон судалж, ус болон цахилгааныг хэмнэх, зохистой ашиглах нь чухал болохыг ухамсарлах замаар тогтвортой хөгжлийн зорилгод хүрэхэд өөриймсөг ханддаг болох, тогтвортой хөгжлийн төлөөх өөрчлөлтийг бүтээхэд хувь нэмрээ оруулах хүсэл эрмэлзлийг төрүүлж болно.

Дүгнэж үзэхэд суурь боловсролын VII-IX ангийн нийгмийн ухааны сургалтын цөм хөтөлбөрийн 12¹²⁵ суралцахуйн зорилт нь ТХЗ-д хамаарах 14 суралцахуйн зорилт, сэдэвтэй илүү нийцсэн гэж үзлээ. Үүнд:

- “Хувь хүн ба нийгэм” агуулгын хүрээний 2 зорилтыг ТХ-ийн 3 зорилготой,
- “Хувь хүн ба соёл” агуулгын хүрээний 2 зорилтыг ТХ-ийн 2 зорилготой,
- “Хувь хүн ба эдийн засаг” агуулгын хүрээний 5 зорилтыг ТХ-ийн 7 зорилготой,
- “Хүний эрх ба хууль” агуулгын хүрээний 3 зорилтыг ТХ-ийн 3 зорилготой тус тус уялдуулж авч үзэв.

Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтын хувьд ТХ-ийн 1, 4, 5, 6, 7, 8, 10, 11, 12, 17 дугаар зорилготой тус тус холбогдсон бөгөөд эдгээрээс ТХ-ийн 8-р зорилготой хамгийн олон буюу 4, ТХ-ийн 4 болон 10-р зорилготой тус бүр 2, дээр дурдсан бусад зорилгод тус бүр 1 зорилтыг харгалзуулсан. Ангиар нь

125 Сургалтын цөм хөтөлбөрийн зарим суралцахуйн зорилт ТХЗ-той давхцсан. Тухайлбал: “Хувь хүн ба эдийн засаг” агуулгын хүрээний VII ангийн “өрх гэр бүлийнхээ хэрэгцээ орлого, зарлагыг судалсны үндсэн дээр хэрэгцээ хязгааргүй түүнийг нөөц баялаг нь хязгаарлагдмал шинжтэй болохыг ойлгон, ухаалаг хэрэглээнд суралцана” гэсэн зорилт нь ТХ-ийн 7,8,12 дугаар зорилготой холбогджээ.

авч үзвэл 7, 8-р ангид тус бүр ТХ-ийн 6 зорилт, 9-р ангид 3 зорилт холбогджээ. Мөн нийгмийн ухааны суралцахуйн зорилтыг ТХ3-д хамаарах суралцахуйн зорилтын гурван аятай хэрхэн холбогдсоныг авч үзвэл,

- танин мэдэхүйн чиглэлийн суралцахуйн зорилт 5,
- нийгэмшил-сэтгэл хөдлөлийн чиглэлийн суралцахуйн зорилт 5,
- зан үйлийн чиглэлийн суралцахуйн зорилт 4 байна.

Суурь боловсролын түүхийн хичээлээр сурагчид ТХБ-той холбогдох дараах агуулгыг илүү судлах боломжтой байгаа нь шинжилгээний үр дүнгээс харагдлаа. Үүнд:

- Нүүдлийн соёл иргэншлийн онцлог, үнэт зүйл;
- Дэлхийн I, II дайн, хүйтэн дайн, энх тайван;
- Дэлхийн улс орнууд, бүс нутгуудын тэгш бус хөгжил;
- Улс орны нийгэм, эдийн засаг, соёл, боловсролын хөгжил, өөрчлөлт гэх мэт.

Тухайлан жишээ болгож авч үзвэл:

- YI ангийн “Эртний хүмүүсийн хувьсал, өөрчлөлт, аж амьдрал, тэдний суурьшил болон нүүдэл тархалт, ...2-ыг сонирхон судлах” хүрээнд эртний хүмүүсийн нүүдэл, суурьшлын түүхийг тэдний хоол хүнсний олдоц, тухайн үеийн цаг уурын байдалтай холбон авч үзэх бөгөөд ингэснээр ТХ-ийн 2-р зорилгын хүрээнд тодорхойлсон “Сурагч өлсгөлөн, хүнс тэжээлийн дутагдлыг тухайн орон нутаг, үндэстэн, дэлхий нийтийн түвшин дэх тоо хэмжээ, тархалтын талаарх өнөөгийн байдлыг, түүнчлэн түүхийг мэддэг болох” суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулж чадна. Мөн энэхүү агуулгын хүрээнд “Зарим улс орны хүмүүс яагаад эх нутгаасаа дүрвээд, нүүгээд байна вэ?” гэдэг асуултыг тавьснаар тэдний түүхийн мэдлэгийг өнөө цагтай холбож, дайн, ядуурлын тухай эргэцүүлэхэд нь туслах боломжтой юм.
- Мөн YI ангийн “Монгол нутаг дахь эртний нүүдэлчид, хүн байгалийн холбоо, зохицол, нүүдлийн мал аж ахуй нь нүүдлийн иргэншлийн гол онцлог болохыг монголчуудын эрхлэх аж ахуй, хоол хүнс, хувцас хэрэглэл, гэр сууцны түүхийг сурвалжлах замаар олж мэдэх” агуулгын хүрээнд “өнөөгийн дэлхийн хүн амын хоол хүнс, цаг ууртай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд нүүдлийн соёл иргэншлийн туршлага, өв тус болох юм биш байгаа?!” гэдэг асуудлыг тавьж хэлэлцүүлснээр ТХБ-д хувь нэмэр оруулж чадна.
- IX ангийн “Богдын засгийн газраас үндэсний тусгаар тогтнол, эдийн засаг, аж ахуй, соёлын хөгжлийн талаар авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааг ойлгож, өнөөгийн байдалтай холбон ярилцах” хүрээнд 1915 оны сургуулийн дүрэм, нугалбар бичиг зэргийг ашиглан жендэрийн тухай авч үзэх, тухайлбал, зөвхөн хөвгүүд гэсэн заалт байгаа нь жендэрийн талаарх тогтсон хандлагатай хэрхэн холбогдох талаар хэлэлцүүлэг хийж ТХ-ийн 5-р зорилготой холбоно.¹²⁶

Суурь боловсролын түүхийн хичээлийн хүрээнд дэлхийн түүхийн 2, монголын түүхийн 10 суралцахуйн зорилтыг холбон сонгосон. Энд нүүдлийн соёл иргэншилтэй холбоотой 4, дайны түүхтэй холбоотой 2, шинэ үеийн монгол улсын нийгэм, эдийн засаг, соёлын түүхтэй холбоотой 3 суралцахуй зорилт байна.

¹²⁶ Түүхийн хичээлээр монголчуудын жендэрийн уламжлалт хандлагыг авч үзэх нь багш, сурагчдын хувьд шинэ тутам тул энэхүү агуулгаар нэгж хичээлийн үлгэрчилсэн хөтөлбөр боловсруулсан болно.

Бүрэн дунд боловсролын түвшинд нийгмийн ухааны сургалтын цөм хөтөлбөрт шинжлэх ухааны мэдлэг, ойлголтыг судлах замаар аливаа асуудалд шинжлэх ухаанчаар хандах зорилтыг илүү тусгасан бөгөөд энэ хэрээр ТХ3-д хамаарах танин мэдэхүйн суралцахуйн зорилттой илүү холбогдож байна. Үүний зэрэгцээ нийгэм, соёлын болон зан үйлийн суралцахуйн зорилтууд сурагчдын эзэмших үнэт зүйл, хандлага талаасаа тодорхой хэмжээнд тусгагджээ. Тухайлбал, “Нийгэм, нийгмийн харилцаа” бүлэг сэдвийн “Ядуурал нь тэгш бус байдал, эрх мэдэл, ашиг сонирхлын ялгаатай байдалтай холбоотой ойлголт болохыг нийгмийн давхраажилтын онолын үүднээс тодруулан авч үзэх” агуулга нь ТХ3-д хамаарах ТХ301.ТМЗ¹²⁷ суралцахуйн зорилт болон санал болгосон “Ядуурлын тодорхойлолт” гэсэн сэдэвтэй нийцэж байна. Сургалтын цөм хөтөлбөрийн энэхүү агуулгын хүрээнд Үндсэн хуулиар хамгаалагдсан “...эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, агаарын бохирдол, байгалийн тэнцвэр алдагдахаас хамгаалуулах” зэрэг эрхийн хэрэгжилтийг өөрийн гэр бүлийн болон бусад хүмүүсийн амьжиргааны түвшин, нийгмийн хамгааллын байдалтай холбон авч үзэх боломжтой юм. Мөн байгалийн хүчин зүйлээс үүдсэн гамшиг, уур амьсгалын өөрчлөлтөөс бий болсон нөлөөлөл, хүрээлэл орчны доройтол зэрэгтэй ч холбож болохоор байна.

Эцэст нь тэмдэглэхэд өмнө дурдсанчлан зөвхөн бидний сонгосон агуулгаар хязгаарлагдаж, тэр хүрээнд л сурагчдад ТХБ олгоно гэсэн үг биш бөгөөд хичээл болон хичээлээс гадуурх ажил гэсэн сургалтын аль ч хэлбэрээр сурагчдын ТХБ-ыг дэмжих нь зүйтэй юм.

Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцыг тодорхойлсон байдал

ТНУ-ны хичээлд ТХ3-ыг хангах сургалтын аргын дотроос дараах арга, үйл ажиллагаа илүү хамаарна. Үүнд:

- Шинжилгээ/ судалгаа хийх:
 - задлан шинжилгээ, судалгаа хийх,
 - тохиолдол шинжлэх,
- Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх:
 - эсээ бичих,
 - хэлэлцүүлэг хийх,
 - дүрд тоглох,
 - экскурс, танилцах аялал хийх,
- Алсын хараатай болох:
 - ирээдүйг төлөвлөх,
 - түүх, намтар зохиох гэх мэт

Үүний зэрэгцээ бодит, хамтын ажиллагаанд оролцох аргуудаас тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, үүнтэй холбоотой арга хэмжээд оролцох болон дүрийн тоглолт хийх зэрэг аргыг ТНУ-ны хичээлд өргөн ашиглана. Тухайлан авч үзэхэд YI ангийн “Эртний хүмүүсийн хувьсал, өөрчлөлт, аж амьдрал, тэдний суурьшил

¹²⁷ Суралцагч ядуурлын шалтгаан болон нөлөөллийн талаар тухайлбал, нөөцийн тэгш бус хуваарилалт, эрх мэдэл, колоничлол, зөрчил мөргөлдөөн, байгалийн хүчин зүйлээс үүдсэн гамшиг, уур амьсгалын өөрчлөлтөөс бий болсон нөлөөлөл, хүрээлэл орчны доройтол, технологийн гамшиг, нийгмийн хамгааллын тогтолцоо, түүнийг үнэлэх хэмжилтийн дутагдалтай байдал зэргийг мэддэг болох

болон нүүдэл тархалт, ...-ыг сонирхон судлах"-даа дүрийн тоглолт хийж, эртний хүмүүсийн хоол ундаар гачигдаж, цаг уурт хавчигдаж байгааг харуулснаар тухайн цаг үеэ мэдэрч, өнөө үеийн өлсгөлөн, түүнээс улбаалан дүрвэж, нүүж байгаа хүмүүсийн бодит байдлыг ойлгох боломжтой юм.

Хүснэгт 4.5.4. Нийгмийн ухааны цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт ба ТХЗ-ыг хангах сургалтын арга

Хичээл, түвшин	Суралцахуйн зорилт	Бодит үйл ажиллагаанд оролцох	Шинжилгээ/ судалгаа хийх	Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх	Алсын хараатай болох	Санал болгосон сургалтын арга	
							СБ
Нийгэм судлал	СБ	14	3	13	13	3	32
	БДБ	17	7	13	9	6	35
Түүх	СБ	12	1	7	12	2	22
Нийт		43	11	33	34	11	89

Дээрх аргууд нь ТНУ-ны хичээлээр шинжлэн судлах арга барилыг эзэмшүүлэх нийтлэг арга зүй бөгөөд эдгээрээс

- Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх аргыг тохиолдол шинжлэхэд,
- Бодит үйл ажиллагаанд оролцох аргыг нийгмийн ухааны хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадвараа амьдрал, практикт хэрэгжүүлэн асуудлаа шийдвэрлэхэд түлхүү ашиглах боломжтой юм.

Эдгээр аргаас ахлах ангийн нийгмийн ухааны хичээлд ялангуяа, шинжилгээ судалгаа хийх, бүтээлч эргэцүүллийн арга зүй шууд холбогдож байна.

Нэгж хичээл

ТХЗ-ыг хангах сургалтын аргуудаас шинжлэн судлах болон бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх аргыг сонгон түүх болон нийгмийн ухааны хичээлийн үлгэрчилсэн хөтөлбөр боловсруулсан болно.

Хүснэгт 4.5.5. Нийгмийн ухааны судлагдахууны нэгж хичээлийн товчоо

Хичээл, түвшин	Анг	Хичээлийн сэдэв	Хичээлийн тойм агуулга		Боловсруулсан	
			ШУ-ны тал	ТХБ-ын тал		
Нийгэм судлал	СБ	XI	Соёл ба тогтвортой хөгжил	<ul style="list-style-type: none"> • Соёл, соёлын үнэт зүйлс • Соёлын олон төрөл тэдгээрийн харилцан нөлөөлөл, өөрчлөлт 	<ul style="list-style-type: none"> - Тогтвортой хөгжил (байгаль, нийгэм, эдийн засаг)-д ээлтэй уламжлалт соёл, ёс заншлын талаар судлах Тухайлбал, байгальтай харилцах уламжлалт ёс заншлын талаар байж болно. 	Рэнцэнгийн Золзаяа (БМДИ, ТМА-ны дарга)

Нийгэм судлал	БДБ	XI	Монгол Улсын ДНБ-ний өсөлт ба ажил эрхлэлтийн хамаарал	<ul style="list-style-type: none"> • Үндэсний эдийн засгийн нэгдмэл үзүүлэлтүүд, тэдгээрийн мөн чанар, онцлог, хамаарлыг мэдэх 	Улс орны эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлын индикаторын нэг үзүүлэлт болох ДНБ ба бүтээмжит, зохистой ажил эрхлэлтийн хамаарлыг тогтоож, улс орныхоо эдийн засгийн хөгжлийн талаар ойлгоно.	Чүлтэм-шаравын Гажиддулам (БМДИ, арга зүйч)
			Түүх	СБ	IX	Монгол Улсын нийгэм, эдийн засаг, соёл (1911-1919 он)

Хүснэгт 4.5.6. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Суурь боловсрол: Түүх)

Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ	Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт	ТХБ	
		ТХЗ-ын суралцахуйн зорилт	ТХЗ-ын сэдэв
1	2	3	4
6. Монгол ба эртний дэлхий: Нэн эртнээс Чингисийн өмнөх үе хүртэл	6. 2.1. Эртний хүмүүсийн хувьсал, өөрчлөлт, аж амьдрал, тэдний суурьшил болон нүүдэл тархалт, ...2 – ыг сонирхон судлах	ТХ302.ТМ2	ТХ302. Сэ04
6. Монгол ба эртний дэлхий: Нэн эртнээс Чингисийн өмнөх үе хүртэл	6. 2.2. Монгол нутаг дахь эртний нүүдэлчид, хүн байгалийн холбоо, зохицол, нүүдлийн мал аж ахуй нь нүүдлийн иргэншлийн гол онцлог болохыг монголчуудын эрхлэх аж ахуй, хоол хүнс, хувцас хэрэглэл, гэр сууцны түүхийг сурвалжлах замаар олж мэднэ	ТХ302.ТМ2.	ТХ302. Сэ09.
9. Орчин үеийн дэлхий дахин:1911 оноос өнөө үе	9, 2.4.а. (БНМАУ)-ын эдийн засаг, нийгэм соёл, боловсролын хөгжлийг судалж, энэ үеийн түүхийн алдаа, оноог эргэцүүлнэ.	ТХ303.НСХ3.	ТХ303. Сэ03.
	9, 2.1.а. Богдын засгийн газраас ...соёлын хөгжлийн талаар авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааг ойлгох, өнөөгийн байдалтай холбон ярилцана.	ТХ304.НСХ3.	ТХ304. Сэ04.

	9, 2.1.а. Богдын засгийн газраас үндэсний тусгаар тогтнол, эдийн засаг, аж ахуй, соёлын хөгжлийн талаар авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааг ойлгож, өнөөгийн байдалтай холбон ярилцана.	TX305.HCX1.	TX305.Сэ02.
	7, 2.3.б. ...монголчуудын дэлхийн түүхэнд оруулсан хувь нэмрийг тодруулан авч үзэх,...	TX309.HCX1.	TX309.Сэ03.
	7, 2.2.г. Европын феодалын нийгмийн үүсэл ба загалмайтны ертөнцийн талаар ойлголттой болж, эзэн харьяатын ёс	TX310.TM1.	TX310.Сэ10.
	6, 2.2. Дэлхийн эртний соёл иргэншил, түүний дотор нүүдлийн соёл иргэншил, гэр сууцын түүхийг сурвалжлах	TX311.TM3.	TX311.Сэ06.
	8, 2.4.в. ХҮИИ-XX зууны эхэн үеийн өрнө дахины аж үйлдвэржсэн нийгэм, шинжлэх ухааны ололт, нээлтүүд	TX312.TM1.	TX312.Сэ02.
	6, 2.2. Монгол нутаг дахь эртний нүүдэлчид, хүн байгалийн холбоо, зохицол, нүүдлийн мал аж ахуй нь нүүдлийн иргэншлийн гол онцлог болохыг монголчуудын эрхлэх аж ахуй, хоол хүнс, хувцас хэрэглэл, гэр сууцын түүхийг сурвалжлах замаар олж мэднэ	TX315.HCX4.	TX315.Сэ08.
	9, 2.4.б. Дэлхийн 2 дугаар дайн, хүйтэн дайн зэрэг дэлхийн түүхийн үйл явдлыг тухайн үеийн Монгол улсынхаа түүхтэй холбон судална.	TX316.TM1.	TX316.Сэ06.
	9, 2.4.б. Дэлхийн 2 дугаар дайн, хүйтэн дайн зэрэг дэлхийн түүхийн үйл явдлыг тухайн үеийн Монгол улсынхаа түүхтэй холбон судална.	TX316.HCX3.	TX316.Сэ06.

Хүснэгт 4.5.7. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Суурь боловсрол: Нийгэм судлал)

Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ	Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт	ТХБ	
		ТХЗ-ын суралцахуйн зорилт	ТХЗ-ын сэдэв
1	2	4	5
1. Хувь хүн ба нийгэм	8, 1.3. Орон нутгийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулах, идэвх санаачилгатай оролцох талаар шинэ санаа хувилбаруудыг дэвшүүлэхийн зэрэгцээ бусдыг уриалах, нөлөөлөх чадварт суралцуулна	TX301.3Y1.	TX301.Сэ09.
1. Хувь хүн ба нийгэм	8, 1.3. Орон нутгийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулах, идэвх санаачилгатай оролцох талаар шинэ санаа хувилбаруудыг дэвшүүлэхийн зэрэгцээ бусдыг уриалах, нөлөөлөх чадварт суралцуулна	TX306.3Y2.	TX306.Сэ08.

1. Хувь хүн ба нийгэм	8, 1.2.Орон нутгийн хүрээнд тулгамдаж буй асуудал нь хүмүүсийн байр суурь, үүрэг, соёлын ялгаанаас хэрхэн хамаарч байгааг тодруулах замаар нийгмийн бүрдэл хэсгүүдийн хооронд зөрчил үүсэх нөхцөлийг дүгнэн энэхүү зөрчлийн эерэг хийгээд сөрөг талыг ойлгон ухаарч үл ойлголцол зөрчлөөс сэргийлэх арга замд суралцана.	TX305.TM3.	TX305.Сэ01.
2. Хувь ба соёл	9, 2.2.соёл бол үнэт зүйлсийн тогтолцоо болохыг ухааран ойлгож хүндэтгэх, дээдлэх, өвлөх үүргээ ойлгох хүсэл эрмэлзэлтэй болно	TX304.TM4.	TX304.Сэ08.
2. Хувь ба соёл	8, 2.3.Орон нутаг дахь соёлын хожимдлын тулгамдаж буй асуудлаар таамаглал дэвшүүлэн шинжлэн судалж энэхүү соёлыг дээшлүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулахад суралцана.	TX311.HCX5	TX311.Сэ07.
3. Хувь хүн ба эдийн засаг	7, 3.1.өрх гэр бүлийнхээ хэрэгцээ орлого, зарлагыг судалсны үндсэн дээр хэрэгцээ хязгааргүй түүнийг нөөц баялаг нь хязгаарлагдмал шинжтэй болохыг ойлгон, ухаалаг хэрэглээнд суралцана	TX307.HCX1.	TX307.Сэ03.
3. Хувь хүн ба эдийн засаг	7, 3.1.өрх гэр бүлийнхээ хэрэгцээ орлого, зарлагыг судалсны үндсэн дээр хэрэгцээ хязгааргүй түүнийг нөөц баялаг нь хязгаарлагдмал шинжтэй болохыг ойлгон, ухаалаг хэрэглээнд суралцана	TX308.HCX5.	TX308.Сэ02.
3. Хувь хүн ба эдийн засаг	7, 3.1.өрх гэр бүлийнхээ хэрэгцээ орлого, зарлагыг судалсны үндсэн дээр хэрэгцээ хязгааргүй түүнийг нөөц баялаг нь хязгаарлагдмал шинжтэй болохыг ойлгон, ухаалаг хэрэглээнд суралцана	TX312.TM1.	TX312.Сэ05.
3. Хувь хүн ба эдийн засаг	7, 3.3.сургуулийнхаа эдийн засгийн талаарх төсөөллөө өргөжүүлж сургалтын зардлын талаар мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийж тооцоолол хийх чадварт суралцаж зардлыг хэмнэх эрмэлзэлтэй болно	TX317.HCX3.	TX317.Сэ05.
3. Хувь хүн ба эдийн засаг	9, 3.1.Хөдөлмөрийн зах зээлийн талаар судалгаа хийж цалин хөлс, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлэх ажил, мэргэжлийн эрэлтэд судалгаа хийж энэ талаар зөв төсөөлөлтэй болно.	TX308.TM3.	TX308.Сэ06.
3. Хувь хүн ба эдийн засаг	7, 3.2.өрх гэр бүлийн гишүүдийн хөдөлмөрийн хуваарийг ажиглан өөрийн оролцоог тодорхойлон хувь нэмрээ оруулдаг болно.	TX308.HCX4.	TX308.Сэ02.
3. Хувь хүн ба эдийн засаг	8, 3.1. Орон нутгийнхаа үйлдвэрийн газруудын үйл ажиллагаатай танилцах замаар хүмүүс баялгийг хэрхэн үйлдвэрлэдэг, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын ямар хэлбэрийг ашигладаг, үйлдвэрлэлийн нөөц, түүний хязгаарлагдмал болохыг ойлгож, нөөцийн ашиглалттай холбоотой орон нутагт гарч буй асуудлуудыг шийдэх хувилбарыг гаргаж, өөрийн хувь нэмрийг үндэслэж хэрэгжүүлдэг болно.	TX308.3Y3.	TX308.Сэ10.

4. Хүний эрх ба хууль	8, 4.3.Орон нутгийн амьдрал үйл ажиллагааны жишээн дээр хүний эрхийн зөрчлийг ялган таньж, дүрэм журам хуулийн хүрээнд хүний эрхийг хэрхэн хамгаалдаг талаар дүгнэлт гаргаж зөвлөмж боловсруулах аргачлалд суралцана	ТХ310.3Y3.	ТХ310.Сэ03.
4. Хүний эрх ба хууль	7, 4.1. Хүүхэд өөрийн хөгжих, сурч боловсрох, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхээ илрүүлэх	ТХ304.ТМ2.	ТХ304.Сэ01.

Хүснэгт 4.5.8. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бүрэн дунд боловсрол: Нийгэм судлал)

Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ	Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт	ТХБ	
		ТХЗ-ын суралцахуйн зорилт	ТХЗ-ын сэдэв
1	2	3	4
1.Нийгэм, нийгмийн харилцаа	11.1.2.а.Нийгмийн давхраажилтын талаарх онолын тайлбаруудад тулгуурлан нийгэмд өөрийн эзлэх байр суурь, түүнийг өөрчлөх боломжийг тодорхойлох	ТХ301.ТМ3.	ТХ301.Сэ01.
3. Эрх зүй	10.3.2.в.Нийгмийн хамгааллын эрхзүйн зохицуулалтыг танин мэдэж, нийгмийн даатгал, халамжийн харилцаанд оролцох чадвар эзэмших	ТХ303.ТМ3.	ТХ303.Сэ04.
5.Улс төр	10.5.1.а МУ-ын Үндсэн хууль дахь иргэний эрх, үүрэг, хариуцлагын тухай үзэл баримтлалтай холбон тайлбарлах	ТХ304.ТМ2.	ТХ304.Сэ01
1.Нийгэм, нийгмийн харилцаа	11, 1.2.в.Нийгмийн категориуд (угсаатан, жөндөр г.м)-ын талаар эх сурвалжийг судлан, тоон болон чанарлаг шинжилгээ хийн, тогтсон үзэл баримтлалуудын талаарх нотлох, няцаах үндэслэлгээг дэвшүүлэх,	ТХ305.3Y2	ТХ301.Сэ10.
3.Эдийн засаг	10, 4.2.б.Ажилгүйдэлд холбогдох мэдээллийг шинжлэн судалж мэдэх	ТХ308.ТМ1.	ТХ308.Сэ01.
3.Эдийн засаг	10, 4.1.а.Үндэсний эдийн засгийн нэгдмэл үзүүлэлтүүд, тэдгээрийн мөн чанар, онцлог, хамаарлыг мэдэх	ТХ308.ТМ1.	ТХ308.Сэ03.
3.Эдийн засаг	10.4.1.в.Боломжийг эдийн засгийн хувьд дээд зэргээр үр дүнтэй ашиглах хүсэл эрмэлзэлтэй болох	ТХ308.НСХ5.	ТХ308.Сэ01 болох
3.Эдийн засаг	11.4.1.а. Төрөөс эдийн засгийг зохицуулах арга механизм, түүний мөн чанарыг ойлгох	ТХ309.ТМ5.	ТХ309.Сэ05.
6. Олон улсын харилцаа	10.6.3.б. Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцааны зорилго, чиглэлийг бодит жишээ, статистик мэдээллийг ашиглан тодорхойлох	ТХ310.ТМ4.	ТХ310.Сэ05.
2. Соёл	11.2.1.б. Соёлын үйлдвэрлэлийн ДНБ-д оруулж буй хувь нэмрийг тооцоолох, цаашид хөгжих санал, хувилбарыг дэвшүүлэх	ТХ312.3Y4.	ТХ312.Сэ08.

2. Соёл	11.2.3.б. Эх орон, эх дэлхийг хайрлан хамгаалах, бусдын соёлыг хүндэтгэх, амьдралын зохистой үйлд суралцах талаар санаагаа дэвшүүлэх	ТХ312.3Y5.	ТХ312.Сэ10.
4. Эрх зүй	11.3.1.б. Хүний эрхэм чанарын тухай ойлголт, онцлог шинжийг судлан тайлбарлах	ТХ316.ТМ1.	ТХ316.Сэ01.
4. Эрх зүй	11.3.2.а. Үндсэн хууль ёс болон эрх зүйд захирагдах ёсны харилцан хамаарлын талаар судлан мэдэх, өөрийн байр суурийг илэрхийлэх	ТХ316.ТМ2.	ТХ316.Сэ02
4. Эрх зүй	11.3.2.в. Тодорхой тохиолдлоос гэмт хэрэг, гэм хорын ялгааг тодруулах замаар тулгуур ойлголтуудыг эзэмшиж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, аюулгүй аж төрөх нөхцөлийг хэрхэн бүрдүүлэх арга замуудыг тодорхойлох	ТХ316.ТМ3.	ТХ316.Сэ02.
6. Олон улсын харилцаа	11.5.3.а.Монгол Улсын "зөөлөн хүч"-ний (боловсрол, соёл, спорт, хүмүүнлэг г.м) агуулга, чиглэлийн асуудал шийдвэрлэх замаар судлан ойлгож, тайлбарлах	ТХ316.НСХ2.	ТХ316.Сэ06.
6. Олон улсын харилцаа	10.6.1.в. Иргэн бүр улсаа төлөөлдөг болохыг амьдралын жишээнээс ойлгож, өөрийн үйлдлээрээ харуулах	ТХ317.ТМ2.	ТХ317.Сэ05
6. Олон улсын харилцаа	11.5.2.б. Монгол Улс ба НҮБ, бусад олон улсын байгууллагын хамтын ажиллагааны талаар үнэлэлт өгч, байр сууриа илэрхийлж, санал дэвшүүлэх	ТХ317.3Y2.	ТХ317.Сэ02.

4.5.2. Суурь боловсролын түүхийн хичээл

4.5.2.А. ТХБ-д суурь боловсролын түүхийн хичээлээр оруулах хувь нэмэр

ЕБС-ийн түүхийн хичээлийг судалснаар сурагчид эх орныхоо өнгөрсөн үеийн түүхээр бахархаж, үндэсний адилсал, үнэт зүйлийг эзэмших, уламжлахын зэрэгцээ түүх, нийгмийн үзэгдэл, үйл явдлыг өнгөрсөн, одоо, ирээдүй үеийн гурван цагийн холбоонд авч үзэх мэдлэг, чадвар, сэтгэлгээгээ хөгжүүлдэг. Сурагчид түүхийг судлах явцдаа:

- эх сурвалжтай ажиллах,
- өнгөрсөн одоог харьцуулах,
- туршлага, шалтгаан үр дагавар, сургамжийг тодорхойлох,
- үзэл бодлын зөрүүг тайлбарлах,
- ирээдүйг төсөөлөх зэрэг тухайлан түүхийн сургалтаар эзэмших тусгай чадвараа хөгжүүлж байдаг.

Сурагчид түүхийн хичээлээр дээр тэмдэглэсэн чадвараа хөгжүүлж, хэрэглэж сурснаар ТХБ-д түүхийн хичээлийн оруулах хувь нэмэр хангагдах учиртай. Тухайлбал,

- Сурагчид түүхэн эх сурвалжтай ажиллах арга барил, чадвараа ашиглан хүн төрөлхтний тогтвортой хөгжихөд тулгарч буй сорилт, бэрхшээл, түүний үүсэл түүхийн талаарх эх сурвалжийг задлан шинжлэх боломжтой.
- Тэд өнөөгийн дэлхий ертөнцийн тулгамдсан асуудлын түүхэн үүсэл, учир шалтгааныг эх сурвалжид үндэслэн авч үзэх болно.

- Мөн хүн төрөлхтний хуримтлуулсан туршлага, шалтгаан үр дагаврыг судлан тодорхойлох чадвараа ашиглан өнөөгийн бидний өмнө тулгарч буй байгаль, экологитой холбогдсон асуудлын шийдлийг нүүдлийн соёл иргэншлийн онцлог, үнэт зүйлстэй холбон танин мэдэх, тайлбарлах боломжтой.

Түүхийн хичээлийн хувьд ТХЗ-д хамаарах танин мэдэхүйн, нийгэм сэтгэл хөдлөлийн, зан үйлийн айн хүрээнд тодорхойлсон суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулна. Тухайлбал,

- Танин мэдэхүйн хувьд сурагчид хүн төрөлхтний өмнө тулгараад буй сорил бэрхшээл, шийдвэрлэх асуудлын үүх түүхийг судлан мэднэ. Тухайлбал, эртний хүмүүсийн нүүж, тархан суурьшсан нэг шалтгаан нь хоол тэжээлийн дутагдал, хомсдол байсан тухай, хүн төрөлхтөнд дайн дажны учруулсан хор уршиг зэргийг тодорхойлж сурна.
- Нийгэмшил-сэтгэл хөдлөлийн суралцахуйн зорилт нь хүн төрөлхтний амьдрах орчин, соёлын үнэ цэн, зарчим нь тэдний түүх соёл, ёс заншилтай холбоотойгоор олон янз байдгийг ойлгох, үнэлэх дүгнэхтэй холбоотойг өмнө тэмдэглэсэн. Сурагчид түүхийг судлахдаа цаг үргэлж “цаг хугацааны аялал”-д гарч, тухайн цаг үеийн хүмүүстэй “танилцаж”, тэдний оронд өөрийгөө тавих боломж бүрддэг. Түүх судалснаар түүхэн хувь хүмүүс, соёл, хэм хэмжээний олон талт байдлыг ойлгож, хүндэтгэж сурна. Тухайлбал, дэлхийн II дайны түүхээр еврей нарыг хомроглон устгасан түүхийг судалсан хүүхдүүд шударга ёс, ялгаварлан гадуурхалтын талаар өөрийн гэсэн үзэл бодлыг бий болгож, тэгш байдал, энх тайван, хүний эрхийг хүндэтгэх, хүлээн зөвшөөрөх ёстойг ойлгоно.
- Зан үйлийн хувьд тавьж буй суралцахуйн зорилт нь түүхийн хичээлээр эзэмшсэн тодорхой ур чадвараа ашиглан тодорхой үйл ажиллагаанд оролцох, хийх, түүнд бэлэн байхад чиглэгдэнэ. Тухайлбал, сурагчид нүүдлийн иргэншлийн түүх, үнэт зүйлийг судалснаар түүний байгаль орчинтойгоо зохистой харилцаж, байгалиа амьдчилан үзэх ёс уламжлалыг танин мэдсэнээр түүнийг хадгалах, хамгаалах үйлсэд гар бие оролцох, ийм чиглэлийн үйл ажиллагааг санаачлах, гүйцэтгэх нь чухал гэдэгт итгээж үнэмших, хийх хэрэгжүүлэхэд суралцана.

Хүснэгт 4.5.9. Суралцахуйн зорилт арга зүй, цогц чадамжийн интварац (Суурь боловсрол: Түүх)

Анги	Цогц чадамж	ТХЗ																	
		Бодит үйл ажиллагааны оролцох (компаний ажил, тэмцэлтэй өөр)	Шинжлэх судалгаа хийх (суралцахуйн төсөл, кейс судалгаа, затварчлах)	Бүтээл, шүүмжлэлтэй сэтгэх	Альчн хараратай болох (нээгдэгийг төлөөлөх хийх үйлчилгээ, үлонтөрийн үйлчилгээ)	Аргын сонголсон үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	Код												
1 Бүтэц сэдэв/Агуулгын хүрээ	Цогц чадамж	1	Монгол ба эртний дэлхий: Нэн үе хүртэл	6	Урьдчилсан үндэслэл, аж ахуйн үйл ажиллагааны оролцох (компаний ажил, тэмцэлтэй өөр)	7	Аргын сонголсон үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	8	Түүхэн үйл явдлыг судалж буй урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	9	1 - Эртний хүмүүс хоол хийх болон байхал, цаг үеийн холбоотойгоор аялаха зүйлийн харилцаа хамаарлыг харуулна. 2 - Үүний зэрэгцээ түүхийн мэдлэгийг өнөө үеэс холбон өнөөгийн дэлхийн хүн амын хоол хийх, хэрэглээ, үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	10	Монголчууд аялаха зүйлийн харилцаа хамаарлыг харуулна. 2 - Үүний зэрэгцээ түүхийн мэдлэгийг өнөө үеэс холбон өнөөгийн дэлхийн хүн амын хоол хийх, хэрэглээ, үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад						
		2	Монгол нутаг дахь эртний нүүдэлчид хүн байгалийн холбоо, зохицол, нүүдлийн мал аж ахуй нь нүүдлийн иргэншлийн гол онцлог болохыг Монголчуудын үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	3	Монголчуудын үйл ажиллагааны оролцох (компаний ажил, тэмцэлтэй өөр)	4	Шинжлэх судалгаа хийх (суралцахуйн төсөл, кейс судалгаа, затварчлах)	5	Бүтээл, шүүмжлэлтэй сэтгэх	6	Аргын сонголсон үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	7	Түүхэн үйл явдлыг судалж буй урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	8	Түүхэн үйл явдлыг судалж буй урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	9	1 - Эртний хүмүүс хоол хийх болон байхал, цаг үеийн холбоотойгоор аялаха зүйлийн харилцаа хамаарлыг харуулна. 2 - Үүний зэрэгцээ түүхийн мэдлэгийг өнөө үеэс холбон өнөөгийн дэлхийн хүн амын хоол хийх, хэрэглээ, үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	10	Монголчууд аялаха зүйлийн харилцаа хамаарлыг харуулна. 2 - Үүний зэрэгцээ түүхийн мэдлэгийг өнөө үеэс холбон өнөөгийн дэлхийн хүн амын хоол хийх, хэрэглээ, үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад
		3	Монгол нутаг дахь эртний нүүдэлчид хүн байгалийн холбоо, зохицол, нүүдлийн мал аж ахуй нь нүүдлийн иргэншлийн гол онцлог болохыг Монголчуудын үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	4	Монголчуудын үйл ажиллагааны оролцох (компаний ажил, тэмцэлтэй өөр)	5	Шинжлэх судалгаа хийх (суралцахуйн төсөл, кейс судалгаа, затварчлах)	6	Бүтээл, шүүмжлэлтэй сэтгэх	7	Аргын сонголсон үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	8	Түүхэн үйл явдлыг судалж буй урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	9	1 - Эртний хүмүүс хоол хийх болон байхал, цаг үеийн холбоотойгоор аялаха зүйлийн харилцаа хамаарлыг харуулна. 2 - Үүний зэрэгцээ түүхийн мэдлэгийг өнөө үеэс холбон өнөөгийн дэлхийн хүн амын хоол хийх, хэрэглээ, үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	10	Монголчууд аялаха зүйлийн харилцаа хамаарлыг харуулна. 2 - Үүний зэрэгцээ түүхийн мэдлэгийг өнөө үеэс холбон өнөөгийн дэлхийн хүн амын хоол хийх, хэрэглээ, үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад		
		4	Монгол нутаг дахь эртний нүүдэлчид хүн байгалийн холбоо, зохицол, нүүдлийн мал аж ахуй нь нүүдлийн иргэншлийн гол онцлог болохыг Монголчуудын үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	5	Монголчуудын үйл ажиллагааны оролцох (компаний ажил, тэмцэлтэй өөр)	6	Шинжлэх судалгаа хийх (суралцахуйн төсөл, кейс судалгаа, затварчлах)	7	Бүтээл, шүүмжлэлтэй сэтгэх	8	Түүхэн үйл явдлыг судалж буй урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	9	1 - Эртний хүмүүс хоол хийх болон байхал, цаг үеийн холбоотойгоор аялаха зүйлийн харилцаа хамаарлыг харуулна. 2 - Үүний зэрэгцээ түүхийн мэдлэгийг өнөө үеэс холбон өнөөгийн дэлхийн хүн амын хоол хийх, хэрэглээ, үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	10	Монголчууд аялаха зүйлийн харилцаа хамаарлыг харуулна. 2 - Үүний зэрэгцээ түүхийн мэдлэгийг өнөө үеэс холбон өнөөгийн дэлхийн хүн амын хоол хийх, хэрэглээ, үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад				
		5	Монгол нутаг дахь эртний нүүдэлчид хүн байгалийн холбоо, зохицол, нүүдлийн мал аж ахуй нь нүүдлийн иргэншлийн гол онцлог болохыг Монголчуудын үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	6	Монголчуудын үйл ажиллагааны оролцох (компаний ажил, тэмцэлтэй өөр)	7	Шинжлэх судалгаа хийх (суралцахуйн төсөл, кейс судалгаа, затварчлах)	8	Бүтээл, шүүмжлэлтэй сэтгэх	9	Аргын сонголсон үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	10	Монголчууд аялаха зүйлийн харилцаа хамаарлыг харуулна. 2 - Үүний зэрэгцээ түүхийн мэдлэгийг өнөө үеэс холбон өнөөгийн дэлхийн хүн амын хоол хийх, хэрэглээ, үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад						
		6	Монгол нутаг дахь эртний нүүдэлчид хүн байгалийн холбоо, зохицол, нүүдлийн мал аж ахуй нь нүүдлийн иргэншлийн гол онцлог болохыг Монголчуудын үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	7	Монголчуудын үйл ажиллагааны оролцох (компаний ажил, тэмцэлтэй өөр)	8	Шинжлэх судалгаа хийх (суралцахуйн төсөл, кейс судалгаа, затварчлах)	9	Бүтээл, шүүмжлэлтэй сэтгэх	10	Аргын сонголсон үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	11	Монголчууд аялаха зүйлийн харилцаа хамаарлыг харуулна. 2 - Үүний зэрэгцээ түүхийн мэдлэгийг өнөө үеэс холбон өнөөгийн дэлхийн хүн амын хоол хийх, хэрэглээ, үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар урьдчилсан үндэслэл, зарчмуудыг тайлбар/суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад						

9. Орчин үеийн дэлхий дахин: 1911 оноос өнөө үе	9. 2.4 а. (БНМАУ)-ын эдийн засаг, нийгэм, соёл, боловсролын хөгжлийн төлөвлөгөөний тухайн алдаа, оноог эргэцүүлнэ.	✓	Агуулаа: • БНМАУ-ын нийгэм, соёлын бодлогын хүрээнд явуулсан Соёлын дэвсгэлийн Тодруулга авч үзэх-ТХБ-той холбох; • "Соёлын дэвсгэлээ"-ны Учир шалтгааныг бүх нийтийн зэрүү мэдч, сайн сайхан байдалтай холбон авч үзнэ. Мөн төрөөс энэ чиглэлээр явуулж буй судалгааг мөн чанараг судална.	✓	Тухайн сэдвийг судалж байх үедээ өөрийн эрүүл мэндэд хэрэгсэл хамгаалаад чиглэсэн үйл ажиллагаанд хэрхэн оролцдог талаар яригдаж, сургуулийн зүйгээс болон олон нийтийн дунд зохион байгуулж буй энэ зорилготой арга хэрэгсэл байдал түүнийгээ үргэлжлэн таллаар авч үзэх.....	Түүхэн үзэгдэл, үйл явдлыг судлахдаа түүний судлаж, судалнаар өөр өөрийн үзэлтэй зэрэгцээ болоход нөлөөлж нь энэхүү тогтч чадамгийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулна.
9. 2.1 а. Бодын засгийн газраас үндэсний тусгаар хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа, өртөг, өндөр амжилттай хийгдсэн байдалтай холбоон яриглана.	✓	TX303 Cэ03 TX303 HCX3	Агуулаа: • 1911-1919 оны боловсролын тухай, анхны сургууль байгуулагдсан тухай Тодруулж авч үзэх-ТХБ-той холбох; • ...сургуулийн анхны дүрэм, судалж байсан, хичээл, хичээлийн арга хэрэгсэл, тодруулан авч үзэх, тухайн үеийн энэ чиглэлээрх баримтыг өнөөгийнхтэй харьцуулах, дүгнэх, боловсролын ач холбогдлыг ярилцах	✓	БЭГ яагаад сургууль байгуулахыг чухалчилсан, сургууль боловсрол ямар ач холбогдолтойг эргэлцүүлэн ярилцаж, эсээ бичиж, хэлэлцүүлж хийх боломжтой.	Түүхийн аль ч үед боловсрол, соёлын талаар явуулсан бодлого, үйл ажиллагааг судалснаар боловсролын үр-дүнд ач холбогдлыг урьдчилж ойлгох, үнэлэх, чадвартай болохын зэрэгцээ өөрийн боловсролын зорилгоо тодорхойлж чадна.
9. 2.1 а. Бодын засгийн газраас үндэсний тусгаар хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа, өртөг, өндөр амжилттай хийгдсэн байдалтай холбоон яриглана.	✓	TX305 HCX1	Агуулаа: • 1911-1919 оны боловсролын тухай, анхны сургууль байгуулагдсан тухай Тодруулж авч үзэх-ТХБ-той холбох; • ...сургуулийн дүрэм, судалж байсан, хичээл, хичээлийн арга хэрэгсэл, тухайлбал, зөвхөн хөвгүүд гэсэн заалт байгаа нь жэндэрийн талаарх тогтсон хандлагатай хэрхэн холбогдох талаар жөндөх боломжтой.	✓	Агуулаа: • 1911-1919 оны боловсролын тухай, анхны сургууль байгуулагдсан тухай Тодруулж авч үзэх-ТХБ-той холбох; • ...сургуулийн дүрэм, судалж байсан, хичээл, хичээлийн арга хэрэгсэл, тухайлбал, зөвхөн хөвгүүд гэсэн заалт байгаа нь жэндэрийн талаарх тогтсон хандлагатай хэрхэн холбогдох талаар судлах боломжтой.	Тогтсон хандлага, хоёрдодсон ёс уламжлалд шүүмжлэлтэй хандаж, жэндэрийн тэгш байдлыг хүлээн зөвшөөрнө.

7. 2.3.б. ...монголчуудын дэлхийн түүхэнд оруулсан хувь нэмрийг тодруулан авч үзэх....	✓	TX309 HCX1 TX309 Cэ03	Агуулаа: • Монголчуудын дэлхийн түүхэнд оруулсан хувь нэмрийн нэг нь морин өртөө, улаа болох тухай холбох; • Морин өртөөнөөс эхэлсэн өнөөгийн байдал, түүний зам тээврийн хөгжлийн ач холбогдол, анхаарах асуудлыг авч үзэх, мэтгэгцэх боломжтой (аюулгүй байдал ба дэд бүтэц)	✓	Зам харилцаа, мэдээллийн солилцооны хөгжлийн өөрийн үзэл бодлыг бий болгох	Зам харилцаа, мэдээллийн солилцооны хөгжлийн өөрийн үзэл бодлыг бий болгох
7. 2.2.г. Европын федералын засаглалын өргөжин тэлэлтийн үйл ажиллагаа, ойлголтой болж, эзэн харьяатан ёс	✓	TX310 TM1 TX310 Cэ10	Агуулаа: • Европын гол улсуудын үүсэл, харьяатан, ёс зээн, харьяатан, ёс Тодруулж авч үзэх-ТХБ-той холбох; • Феод газар эзэмшигчид илүү боломжтой болсон нь тэгш бус байдлыг бий болгож, мэдээлэл, харьцаа болж тухай тодруулж авч үзэх. Улмаар нийгмийн гарал, өмч эзэмшиж байдал зэрэг нь тугш бус байдлыг бий болгодгийг дүгнэх боломжтой	✓	Тухайн аргуулын хүрээнд нийгэмд тэгш бус байдлыг бий болгож зүйлсийг задлан ялгах хэлэлцэх	Өмчийн алаатай байдал нь нийгмийн тэгш болж байдлыг бий болгож улмаар хүмүүсийн аж амьдралд нөлөөлж буй холбоо углдааг танин мэдсэнээр өргөжин тэлэх чадвар хөгжихөд дэмжлэг үзүүлнэ.
6. 2.2. Дэлхийн эртний соёл - иргэшил, түүний дотор нүүдлийн соёл иргэшил, гэр суудын түүхийг сууралжлах	✓	TX311 TM3 TX311 Cэ06	Агуулаа: • Нүүдэлчдийн сууд - гэр суудын ач үзэх-ТХБ-той холбох; • Монгол гэрийн архитектурын онцлог, шийдлийг авч үзэх, өнөөгийн ТХ-д тулгамдаж буй асуудлыг шийдэхэд түүний давуу талыг ашиглах боломж, шийдэл, үр дүндийг судалж, сэрээгээ эрчим хүчийг ашиглах байдлыг хэвээр хадгалан хөгжүүлэх....	✓	Монгол гэрийн үүсэл түүний архитектурын онцлог шийдлийн (сэрээгээ эрчим хүчийг ашиглах) талаар хэлэлцэх	Монгол гэрийн өнөөгийн үүсэл, түүний өсөлт, шийдэл, үр дүндийг судалж, сэрээгээ эрчим хүчийг ашиглах байдлыг хэвээр хадгалан хөгжүүлэх, төлөвшилөд цогц чадвар оруулна.

<p>8, 2.4.в. ХҮИИ-ХХ зууны эхэн үеийн өрнө дахины аж үйлдвэржсэн нийгэм, шинжлэх ухааны ололт, нээлтүүд</p>	<p>TX312.ТМ1</p>	<p>TX312.Сә02</p>	<p>Агуулга: • Шинжлэх ухааны ололт нээлтүүд, аж үйлдвэрийн хувьсгал тодруулж авч үзэх-ТХБ-той холбох; • Бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхэлдэг хүчээ, шинжлэх ухааны нээлттэй холбох, мөн хувь хүмүүсийн хэрэглээний түүхийг судлах замаар энэ түүхийг тодруулах авч үзэх, хүмүүсийн хэрэглээг нийгэм, эдийн засаг хүрээлэн буй орчинд хэрэглэх түүхийн талаарх боломж.</p>	<p>ШУ-ны ололт-байгаль-хүний харгалз гэсэн ойлголтуудын холбоог, тодруулан хэлэлцэнэ.</p>	<p>6</p>	<p>...аливаад шүүмжлэлтэй хандаж эргэцүүлэлтэй сурах...</p>
<p>6, 2.2. Монгол нутаг үндэс үндэслэл, үндэс байгалийн мөргөлдөөн, зохиол, нүүдлийн мөргөлдөөн, үндэсний мөргөлдөөн, үндэсний мөргөлдөөний гол онцлог болохыг монголчуудын эрхлэх аж ахуй, хоол тусам, хууцас хэрэглэл, хувь нэмэр оруулах замаар олж мэднэ</p>	<p>TX315.НСХ4</p>	<p>TX315.Сә08</p>	<p>Агуулга: • Монголын нүүдлийн мөргөлдөөн, үндэсний мөргөлдөөн, үндэсний мөргөлдөөний гол онцлог байгаль, уур амьсгалтайгаа дасан зохицсон байдал тодруулж авч үзэх-ТХБ-той холбох; • хүмүүс бол байгалиас салаанд бус харин байгалийн нэг хэсэг болохыг тусгайлан авч үзэх</p>	<p>Хүмүүс, хувь хүний зүгээс байгальтай харилцах буй байдалдаа шүүмжлэлтэй хандаж, байгальд үзүүлж байгаа өргө мөргөлдөөн талаар хэлэлцэнэ</p>	<p>6</p>	<p>Хүмүүс, хувь хүний зүгээс байгальтай харилцах буй байдалдаа шүүмжлэлтэй хандаж, байгальд үзүүлж байгаа өргө мөргөлдөөн талаар хэлэлцэнэ</p>
<p>9, 2.4.б Дэлхийн 2 дугаар дайн, хүйтэн дайн, хүйтэн дайн дэлхийн түүхийн үйл явдлыг тухайн үеийн Монгол улсынхаа түүхтэй холбон судална.</p>	<p>TX316.ТМ1</p>	<p>TX316.Сә06</p>	<p>Агуулга: • Дэлхийн 2 дугаар дайны шалтгаан, үйл явц, хүйтэн дайн түүний төгсгөл тодруулж авч үзэх-ТХБ-той холбох; • Аливаа дайны түүхийг судлахдаа дэлхий дахины энх тайван байдал, хойно үйлдвэрлэл, хөдөлмөр, хөдөлмөр авч үзэх, төр засаг болон олон улсын байгууллагуудын энэ чиглэлээрх үүргийг авч үзэх, тухайлбал, НҮБ</p>	<p>Дэлхийн II болон хүйтэн дайн шалтгаан, үйл явц, хүйтэн дайн түүний төгсгөл тодруулж авч үзэх-ТХБ-той холбох; • Дэлхийн 2 дугаар дайн, хүйтэн дайн түүний төгсгөл тодруулж авч үзэх-ТХБ-той холбох; • Аливаа дайны түүхийг судлахдаа дэлхий дахины энх тайван байдал, хойно үйлдвэрлэл, хөдөлмөр, хөдөлмөр авч үзэх, төр засаг болон олон улсын байгууллагуудын энэ чиглэлээрх үүргийг авч үзэх, тухайлбал, НҮБ</p>	<p>6</p>	<p>Дайны үр дагавар, энх тайвныг хэрхэн сэргээх, хөдөлмөр, хөдөлмөр авч үзэх, төр засаг болон олон улсын байгууллагуудын энэ чиглэлээрх үүргийг авч үзэх, тухайлбал, НҮБ</p>
<p>9, 2.4.б Дэлхийн 2 дугаар дайн, хүйтэн дайн, хүйтэн дайн дэлхийн түүхийн үйл явдлыг тухайн үеийн Монгол улсынхаа түүхтэй холбон судална.</p>	<p>TX316.НСХ3</p>	<p>TX316.Сә06</p>	<p>Агуулга: • Дэлхийн 2 дугаар дайны шалтгаан, үйл явц, хүйтэн дайн түүний төгсгөл тодруулж авч үзэх-ТХБ-той холбох; • Аливаа дайны түүхийг судлахдаа дэлхий дахины энх тайван байдал, хойно үйлдвэрлэл, хөдөлмөр, хөдөлмөр авч үзэх, төр засаг болон олон улсын байгууллагуудын энэ чиглэлээрх үүргийг авч үзэх, тухайлбал, НҮБ</p>	<p>II дайны үед хүмүүсийг яс өгч авсарга, амьдралд дэлхийн 2 хугаасан зэргийг түүхэн баримтад тулгуурлан шинжилж түүний учир шалтгаан, хэр уршигийг шүүн хэлэлцэнэ.</p>	<p>6</p>	<p>Аливаа төрлийн агуулам, гурвалжт шударга бус байдалд шүүмжлэлтэй хандаж суна.</p>

4.5.2.Б. Нэгж хичээл: Монгол Улсын нийгэм, эдийн засаг, соёл (1911-1919 он)

Анги: IX

Сэдэв сонгосон үндэслэл, багшид зориулсан тэмдэглэл

“1911-1919 оны Монгол Улсын нийгэм, эдийн засаг, соёл”-ын талаар түүхийн сэдэв агуулга нь багш, сурагчдын хувьд шинэ тутам биш юм. Энэхүү сэдэв агуулгыг бид IX ангиас гадна XI, XII ангийн түүхийн хичээлээр гүнзгийрүүлэн судлах боломжтой. Гэхдээ бид энэхүү сэдвийн хүрээнд ялангуяа, боловсролтой холбоотой агуулгыг судлахдаа ТХЗ, үүний дотор жендэрийн тэгш байдалтай холбон авч үзэж байсан туршлага хомс юм. Мөн багш нарын тухайд ч түүхийн хичээлээр жендэрийн тухай, монголчуудын жендэрийн хэвшмэл ойлголтын талаарх агуулгын хувьд тусгайлан болон холбон судалж байсан жишээ бага байна. Иймийн тул энэхүү сэдвийг сонгож жишиг төлөвлөлт боловсруулсан болно.

Монгол Улсын нийгэм, эдийн засаг, соёл (1911-1919 он) сэдвээр ТХ-ийн “Жендэрийн тэгш байдал: Жендэрийн тэгш байдалд ахиц, амжилт олох, охид, эмэгтэйчүүдэд эрх олгох” 3-р зорилгын хүрээнд сурагчдад соёлын мэдрэмжийг хүндэтгэхийн зэрэгцээ жендэрийн уламжлалт ойлголтыг шүүмжлэлтэйгээр авч үзэх хандлагыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах боломжтой гэж үзсэн.

Жендэрийн тэгш байдлыг хүлээн зөвшөөрөхөд тухайн улс үндэстний түүхэн явцад бүрэлдэн тогтсон үзэл хандлага нөлөөлдөг гэдэгтэй хүний эрхийн судлаачид санал нэгддэг. Тиймээс энэхүү тогтсон хандлагыг өөрчлөх, зөв хандлага төлөвшихөд нөлөөлөхийн тулд эх орныхоо түүхийн тодорхой үе бүрийг судлахдаа тухайн үед тогтож байсан хандлага, үзэл санааг сонирхон судалж, авах гээхийн ухаанаар хандах учиртай. Монголчуудын хувьд эх хүн, эмэгтэй хүнийг дээдэлдэг соёл уламжлалтай ч тэднийг нийгмийн амьдралд оролцуулах, шийдвэр гаргах түвшинд хэргэм зэрэг, эрх ямба олгох тал дээр “Эмэгтэй хүний үс нь урт, ухаан нь богино” гэх мэт хэвшмэл хандлага тогтсон байдаг нь нууц биш юм.

Иймийн тул Богдын Засгийн газраас 1911-1919 оны Монгол Улсын нийгэм, эдийн засаг, соёл”-ын сэдвийн хүрээнд ялангуяа, боловсролын бодлого, үйл ажиллагаатай холбоотой баримт, эх сурвалжтай ажиллуулахдаа жендэрийн тухай авч үзэх боломжтой. Тухайлбал, 1915 онд Богдын Засгийн газраас баталсан “Бага сургуулийн дүрэм”-ийн бунд заалтад зөвхөн “хөвгүүд” гэсэн заалт байгаа нь жендэрийн талаарх тогтсон хандлагатай хэрхэн холбогдох талаар ярилцаж, жендэрийн тэгш байдлыг хүлээн зөвшөөрч сурахад дэмжлэг үзүүлнэ.

Түүхийн хичээлийн агуулга их тул зөвхөн жендэр, хүйсийн тэгш байдлын талаар авч үзэх боломжгүй. Гэхдээ боловсролтой холбоотой түүхэн эх сурвалжтай ажиллах бүхий л үед энэ талаарх асуултыг тавьж болно. Жишээ нь, 1915 оны сургуулийн дүрмийг уншиж, Монгол улсын төр засгаас анх удаа дүрэм баталж, судлах хичээл, хичээлийн цаг зэргийг тогтоосон байгааг ярилцах явцдаа “Долдугаар зүйл. Бага сургуулийн танхимын хөвгүүдэд заан сургах зүйл ану:” хэсэгт “яагаад зөвхөн хөвгүүдэд гэж заасан юм бол? Энэ юутай холбоотой вэ? Охид сургуульд сурдаггүй байсан юм болов уу...?” гэх мэт асуултыг тавьснаар жендэрийн талаарх монголчуудын тогтсон хэвшмэл хандлагын тухай ярилцлагыг өдөөх боломжтой.

Сургалтын хөтөлбөрийн агуулга (суралцахуйн зорилт)

- Богдын засгийн газраас үндэсний тусгаар тогтнол, эдийн засаг, аж ахуй, соёлын хөгжлийн талаар авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааг ойлгож, өнөөгийн байдалтай холбон ярилцана.

ТХЗ

Жендэрийн тэгш байдал: Жендэрийн тэгш байдалд ахиц, амжилт олох, охид, эмэгтэйчүүдэд эрх олгох:

ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт

- Сурагч ахуй соёлын мэдрэмжийг хүндэтгэхийн зэрэгцээ жендэрийн үүрэг, хариуцлагын тухай уламжлалт ойлголтыг шүүмжлэлтэйгээр асуулт тавьж, хүлээн зөвшөөрч чаддаг болох

ТХЗ-д хүргэх санал болгож буй сэдэв

Жендэрийн тэгш бус байдал, уламжлалт жендэрийн үүрэг оролцоо, бүтцийн ялгаварлан гадуурхал (structural discrimination- ялгаварлан гадуурхлын шууд бус, хэвшмэл, ерөнхий хэлбэр)

Хичээлийн үндсэн агуулга

- 1911-1919 оны Монгол улсын соёлын түүхийн хүрээнд боловсролын тухай, түүн дотор анхны сургууль (иргэний) байгуулагдсан тухай судална. Үүний тулд:
 - Богд хааны тэргүүлсэн Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааг эх сурвалж судлах замаар ойлгоно.
 - ... өнөөгийн байдалтай холбон ярилцахдаа дараах асуудлыг хөндөнө, үүнд:
 - өнөөгийн боловсролын байдал;
 - боловсрол яагаад чухал болох, охид яагаад сүүлд сургуульд явах болсон;
 - өөрийн боловсролын зорилгын талаар гэх мэт

ТХБ-той холбогдох байдал

-сургуулийн эрэгтэй, эмэгтэй хүүхдийн тоог ашиглан жендэрийн тухай авч үзэх, тухайлбал, яагаад эрэгтэй хүүхдүүд суралцдаг байсан, охид цөөн буюу бараг байхгүй байгаа нь жендэрийн талаарх тогтсон хандлагатай хэрхэн холбогдох талаар хөндөх боломжтой.
- Бага сургуулийн анхны дүрэм болон өргөх бичгүүдэд шинжилгээ хийж, яагаад хөвгүүдийг суралцуулахыг онцолсны учир шалтгааныг хайх, олох замаар эмэгтэйчүүдийн талаарх уламжлалт (жендэр) ойлголтыг илрүүлнэ.
- Тогтсон хандлага, хоцрогдсон ёс уламжлалд шүүмжлэлтэй хандаж, жендэрийн тэгш байдлыг хүлээн зөвшөөрнө.

Хичээлийн үндсэн үйл ажиллагаа:

- Түүхийн эх сурвалжийг шинжлэх;
- Хэлэлцүүлэг хийх;

Хичээлийн явц: Эх сурвалжтай ажиллаж дараах даалгаврыг гүйцэтгэнэ үү.


- I үе: Эх сурвалжийг унших
- Танил биш үгийг тэмдэглэх, утгыг тайлбарлах
 - Түүхийн нэр томьёо, ойлголтыг ялгах, тайлбар бичих

Тэмдэглэл

Түүхийн эх сурвалж, ялангуяа, анхдагч эх сурвалжийг уншихад хуучирсан үг хэллэг, тухайн үеийн нийгмийн амьдралд ашиглагдаж байсан нэр томьёо зэрэг сурагчийн хувьд "шинэ" үг хэллэг элбэг. Сурагчид ийм үгсийн утга, агуулгыг ойлгохгүйгээр түүхийн эх сурвалжийг шинжлэх боломжгүй юм. Мөн тухайн үеийн найруулга зүйн онцлог, хэв шинжийг монгол хэлний багштай ярилцан сурагчдад таниулах хэрэгтэй. Энэ уншилтын үр өгөөжийг дээшлүүлж, шинжилгээний чанарт нөлөөлнө.

II үе: Эх сурвалж шинжлэх**II.1:** Дараах асуултын хүрээнд эх сурвалжийг шинжилнэ үү.

- Он цаг, газар нутгийг тогтоох: Хэзээ, хаана болсон үйл явдал вэ?
- Түүхэн зүтгэлтнийг тогтоох: Хэн бэ? Юу хийдэг байв?....
- Агуулга-баримт, фактыг ялгах: Юу болов, хэн, юу гэж үзэв, бичив? Хэлэв?

Дараах хүснэгт, бүдүүвчийг ашиглаарай.

№	Эх сурвалж	Шинжилгээ			Тэмдэглэл
		Он цаг, газар нутаг	Түүхэн зүтгэлтэн	Баримт, үйл явдал	

II.2: Дараах асуултын хүрээнд ярилцана уу.

№	Түүхийн агуулгын хүрээнд	№	ТХЗ-той холбогдох хүрээнд
	Богдын Засгийн газраас боловсролын талаар ямар арга хэмжээ авч явуулсан бэ?		Тухайн үед хэн боловсрол эзэмших боломжтой байв?
	Монгол улсад анх хэзээнээс сургуулийн дүрмийг баталж хүн амд боловсрол олгох асуудлыг тодорхой болгов?		Бага сургуулийн дүрмийн зүйл яагаад зөвхөн "хөвгүүдэд", "хөвгүүд" гэх мэтээр заасан юм бол? Энэ юутай холбоотой вэ?
	Боловсролыг хөгжүүлэх нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилтэй хэрхэн холбогдох вэ?		Охид сургуульд сурдаггүй байсан юм болов уу...?
	Энэ үеийн боловсролын үйл ажиллагаатай холбоотой түүхэн гол үйл явдал, он цаг, түүхэн хүмүүсийн талаар ямар мэдээлэл авав?		Боловсрол эзэмших нь улс орны хөгжлөөс гадна хувь хүний хөгжилд ямар ач тустай вэ?

Тэмдэглэл
Анхаарах зүйл

- Хүснэгт ашиглан тэмдэглэл хийх нь эх сурвалжийн уншилтын чанарыг сайжруулж, анхан шатны шинжилгээ хийх арга юм. Хүснэгтийг оновчтой бөглөх замаар эх сурвалжийг анхан шатны байдлаар шинжилснээр дараагийн түвшний шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг гаргах, боловсруулахад чухал.
- Бүдүүвчилж тэмдэглэснээр эх сурвалжуудаа харьцуулан шинжлэхэд илүү тустай байж болох юм. Тухайлбал, уншсан эх сурвалжуудаа он цагийн хувьд дээрх бүдүүвчид тэмдэглэснээр "1912-1917 он (олноо өргөгдсөний хоёрдугаар оноос олноо өргөгдсөний долдугаар он)-ы нийт 5 эх сурвалжийг шинжилсэн байна." гэх байдлаар түүхэн цаг хугацааг илүү тодорхой авч үзэх боломжтой юм.

III үе: Хэлэлцүүлэг: ТХЗ-той холбогдуулан хэлэлцүүлэг хийнэ үү.

Тэмдэглэл Анхаарах зүйл

- Хэлэлцүүлгийн зорилго:
 - Сурагчид жендэрийн хэвшмэл хандлагад шүүмжлэлтэй хандаж, хүйсийн тэгш байдлыг хүлээн зөвшөөрөх ёстой талаар байр сууриа илэрхийлнэ.
- Хэлэлцүүлгийн зохион байгуулалт:
 - Сурагчдад хүрэлцэхүйц мэдээлэл өгсөн байна. (эх сурвалж болон нэмэлт мэдээллээс ашиглаарай.)
 - Байр сууриа илэрхийлэх аргыг ашиглана.
 - Оролцоог хангана.
- Баримтлах дүрэм:
 - Бусдын байр суурийг шүүмжлэхгүй, няцаана.
 - Няцаалт нь баримтад үндэслэнэ. (түүхэн болон эрх зүйн, ёс зүйн үндэслэлийг гол болгоно.)
- Зорьж буй үр дүн:
 - Сурагч бүр жендэрийн хэвшмэл хандлагад шүүмжлэлтэй хандаж, хүйсийн тэгш байдлыг хүлээн зөвшөөрөх ёстой талаар 1-2 үндэслэл гаргасан байна.

IV үе: Дүгнэх: Дараах асуултаас ашиглан дүгнээрэй.

1. Эх сурвалжуудаас тухайн үеийн монголын соёл, боловсролын хөгжилтэй холбоотой ямар зүйлүүдийг мэдэж авав?
2. Эмэгтэй хүнийг нийгмийн амьдралд оролцуулах, шийдвэр гаргах түвшинд хэргэм зэрэг, эрх ямба олгох тал дээр монголчууд ямар байр суурьтай байсан бэ? Өнөө үед энэ тал дээр ямар өөрчлөлт гарав?
3. Тухайн үеийн төрийн бодлого нь эмэгтэйчүүдийн сурч, боловсрох эрхэд хэрхэн нөлөөлж байв? Энэ байдлыг өнөөгийн жендэрийн үүрэг, хариуцлагатай холбон тайлбарлавал ямар дүгнэлт хийж болохоор байна вэ?
4. Монголчуудын хувьд эх хүн, эмэгтэй хүнийг дээдэлж ирсэн уламжлалаас жишээ татвал...?

Эх сурвалж 1:



Эрдэмтэн Ж.Цэвээнээс Автономит монголын Гадаад яаманд өргөсөн Төрийн сургууль байгуулах тухай (1912.3.30) төслийн бичиг хийгээд Автономитын үеийн монголын бага, дунд сургуулийн дүрэм хэмжээг заасан баримт бичиг зэрэг нь тухайн үеийн монголын соёл боловсрол, сургалт хүмүүжлийн ажлын хөгжил дэлгэрлийг харуулах үнэтэй өв, чухал эх хэрэглэхүүн болох юм

Эх сурвалж: Монгол Улсын шинжлэх ухаан, I боть, 2000, 99-10 дахь тал.

1912 оны 3 дугаар сарын 30-нд Гадаад яаманд соёлын асуудал эрхэлсэн туслах түшмэлээр ажиллаж байсан Жамсраны Цэвээн Гадаад яаманд өргөсөн бичиг:

"Ван өршөөж" түмэн монголчуудын эрдэм дор нэвтрүүлэн аж байдлыг нь боловсруулан хүмүүжүүлэх зэргийн явдлыг өчүүхэн буриад Цэвээн надад дор бодомжилтугай хэмээн тушаасан билээ... Гадаадын олон хүчирхэг улсын хамаг чадал ану гагцхүү элдэв ухааны эрдэмд нэвтрэлцэн... зүйл бүрийн ухааныг өөр өөрийн төрөлх хэл дээр судалснаар энэ мэт хүчирхэг болжээ. Гадаад улсын сургууль гурван зэрэг бөгөөд дороос үзэх нь улам бүр гүн дэлгэрэнгүй болсоор амой... төрөлх хэлний ухаан, тоо бодлого, хэмжих зурах ухаан, дүрст бодисыг элдэвчлэх шинжлэх ухаан, ертөнц дэлхийн байдал... эрүүл биеийг сахиж элдэв өвчнийг сэргийлэх ёсон мэт суралцах ухаан цөөн бус... дээр дурдсан нийт ухааны сургуулиас гадна... цэргийн сургууль, эмчлэх сургууль, багшийн сургууль, урлах сургууль, уурхай нээх, худалдаа нээх, тарианы аж, мал аж, сүү тосны аж гэх мэт ямагт нэгэн зүйл ухааныг эрхэлсэн сургууль маш олон болой... учир иймийн тулд хүсэхүй ану: ... гээд Да Хүрээнд дорд сургууль байгуулах, гадаад хэлнээс орос, хятад хэлийг сонгон үзүүлэх, дөрвөн аймагт сургууль байгуулах, сүү тос, мал аж сайжруулах сургууль байгуулах, ухаан бүрийн дэвтрүүдийг монголоор зохиолгох"

Эх сурвалж: БНМАУ.ТТА. "Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг" №7. 10-12 дахь тал

Тайлбарлах үе:

- Автономи, автономийн үе, ван, Да Хүрээ

Эх сурвалж 2:

1915 онд хэвлэн нийтэлсэн “Сургуулийн танхим байгуулж бага хөвгүүдийг эрдэм сургахуй нь” хэмээх сурвалж бичигт:

“Нэгэн зүйл. Нийслэл хүрээ ба олон хошуу, шавийн газар бага, дунд, дээд зэргийн сургуулийн танхим байгуулж бага сургуулиас үүсгэн зүйл бүрийн эрдэм чадлыг сургах зэрэг дэс буй. Олон хан, ван, гүнгийн хөвгүүд, дүү нараас эхлэн аливаа арван наснаас дээш арван таван наснаас дорогш ухаан сэргэлэн хөвгүүдийг цөм сургуульд оруулж тогтоосон дүрэм хэмжээг дагаж явуулмуй. Олон хошуудын бага сургуулийн хөвгүүдэд тогтоосон тоогүй, уул хушууны хүн амын үлэмж цөөний байдалд тэнцүүлэн сургуулилмуй. Нийслэл хүрээний бага, дунд хоёр сургуулийн хөвгүүд бүгд наян хүнээр тоо тогтооно”

Эх сурвалж: Монголын автономит үеийн сургууль, 1966, 7 дахь тал

1915 оны зун Богд хааны зарлигаар батлагдсан энэхүү Бага сургуулийн дүрмийн зарим гол зүйл:

“Нээдүгээр зүйл. Бага сургуулийн танхимд олон чуулган аймаг, хошууд ба шавийн зэрэг газрын аливаа түшмэл тайж ба харц албат нарын хөвгүүдийг зарлан хуруулж сургуульд оруулан таван жилийн хугацааны дотор монгол бичиг үсэг заан сургаж, дараа сэцэн сэргэлэнг нь сонгон авч дунд зэргийн сургуулийн танхимд дэвшүүлэн оруулж зүйл бүрийн эрдэм чадал сургахуй дор тус болговоос зохимуй.

Хоёрдугаар зүйл. Бага сургуулийн танхимын энэхүү дүрэм хэмжээг зарлан явуулсан өдрөөс эхлэн хагас жилийн дотор Нийслэл Хүрээ, Маймаа хотын газраа нэгжгээд олон чуулган аймгийн хошууд ба шавийн зэрэг газар болбоос цөм өөр өөрийн харьяат хошуу

ба шавийн тамгын хэрэг шийтгэх газар ба бүгдийн даргын зэрэг газар нэгжгээдийг эрхгүй тус тус байгуулбаас зохимуй. Түүнээс бичиг үсэг сургах хөвгүүдийн тоог хүн амаар үлэмж цөөний байдалд тэнцүүлэн зохисыг үзэж



Зураг. Оросын консулын дэргэдэх Орос-Монгол орчуулагчийн сургуулийн багш, сурагчид, 1913 он

Эх сурвалж: Монголчууд XX зууны эхэнд зурагт түүх., Мон судар., 2011

сургуулилаас зохимуй. Басхүү тогтоосон жилийн дотор монгол бичигт ор сайнаар боловсрогдогдод харьяат багш өөр зүйлийн бичиг сургууль үйлдүүлбээс зохимуй.

Хүн амаар үлэмжхэн, газар нутгаар уудам бөгөөд бага сургуулийн танхимын тоог нэмэгдүүлэн байгуулж, хөвүүд дүү нарын нэрийг хуваан илгээж, бичиг эрдэм сургахуй дор тус болгосугай хэмээвээс даруй өөрсдийн дураар нэмж байгуулбаас болмуй.

Тавдугаар зүйл. Бага сургуулийн танхимд нийслэл Хүрээ, Маймаа хотын газар болбоос хошуу, шавийг ялгахгүй бусад олон хошууд ба шавийн зэрэг газар бол цөм өөр өөрийн харьяат түшмэл, тайж ба харц албат нарын найман наснаас дээш арван наснаас дорогш хөвгүүдийг бүрнээ зарлан хуруулж сургууль дор оруулбаас зохимуй. Гагцхүү энэ хир албаны сургуулийг сая нээн хөгжүүлэх цаг тул анх удаа дор 18 наснаас дорогш арван наснаас дээш бичиг үсэг сурч төсөөлөөгүй хөвгүүдийг мөн цөм нэгэн адил зарлан хуруулж сургуульд оруулбаас зохимуй.

Долдугаар зүйл. Бага сургуулийн танхимын хөвгүүд дор заан сургах зүйл ану:

Нэгдүгээр: монгол үсгийн бичиг шастир,

Хоёрдугаар: энгийн тоо бодох сургууль,

Гуравдугаар: монгол ба бусад олон газрын байдал төлөв,

Дөрөвдүгээр: аж төрөхийг сайжруулах ёс,

Тавдугаар: Монголын хураангуй түүх

Зургадугаар зүйл: Биеийн судал тамирыг сайжруулан боловсруулах зэрэг зүйлийг гол болгомуй. Бас ч эдгээр заан сургах бичиг дэвтрийг цөм сургуулийн хэргийг захиран шийтгэх яамнаас талбин олгомуй.

Есдүгээр зүйл. Нийслэл Хүрээ, Маймаа хотын бага сургуулийн танхимын сургуулийн хөвгүүдийг өдөр бүр могой цагийн эхэнд зарлан хуруулж, бичиг үсэг заан сургаад бичин цагийн эхэнд тарааж, өөр өөрийн гэр дор буцааваас зохимуй. Түүнээс бусад олон хошууд ба шавийн зэрэг газрын бага сургуулийн танхимын сургуулийн хөвгүүдийг цөм өөр өөрийн сургуулийн танхим дор үргэлжид суулган мөн өдөр бүр могой цагийн эхнээс бичин цагийн эхэн дор хүртэл бичиг үсэг заан сургаваас зохимуй”

Эх сурвалж: МУУТА, Автономитын шинэ фонд, Эх бичиг. 6-31-38

Тайлбарлах үг:

- Нийслэл Хүрээ, хошуу, шавь, тайж, харц албат, Маймаа хот, зааж сургах дэвтэр, могой цаг, бичин цаг, нугалбар бичиг, цэс, дэс

Эх сурвалж 3: 1912 оны 4 дүгээр сарын 6-нд Нийслэл хүрээний бичгийн сургуульд орох хөвгүүдийг Хан Хэнтий уулын чуулганаас тодорхойлон ирүүлэхийг Дотоод яамнаас шаардсан бичигт:

“Илгээх бичиг”

Өргөн тушаан илгээв. Тушаан явуулах учир эдүгээ Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаас тушаан хүрч ирсэн бичигт тушаан явуулах учир: Эдүгээ олноо өргөгдсөний тэргүүн оны өвлийн сүүл сарын гучнаа дотоод яамнаас айлтгасан нь: Аливаа насан бага ван, гүн, засаг, тайж ба тэдний хөвгүүд, дүү нарыг авч олон үсэг бичгийн сургуульд оруулж боловсруулах явдлыг хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад... Иймийн тулд үүнийг Цэцэн хан олон хошуудад хуваан явуулж тушаагаад

өөр өөрийн харьяат ван, гүн, засаг, тайж нар мөн тэдний хөвгүүд дүү нарын дотроос арван наснаас дээш хорин насанд үл хүрсний нь уул тушаасан ёсоор өөр өөрийн хүчнийг хэрэглүүлэн мордуулж цөм тогтоосон болзооны урьд нийслэл Хүрээнд гүйцэн ирүүлж тухайд түүгээр дотоод яамны газар илгээн одуулж, сургуульд оруулахууд бэлтгүүлэхээс гадна, сургуульд оруулбаас зохих арван наснаас дээш хорин нас үл хүрэх ван, гүн, засаг, жич тэдний хөвгүүд дүү нар өөр өөрийн хэд болох ба хэн нэртэй, хэдэн настай болох явдлыг тус тус тодорхойлсон цэс үйлдэж энэ жил хаврын сүүл сарын шинийн нэгэнд дэсээр /зэргээр/ мэдүүлэн ирүүлээд уламжлан мэдээлэхүүд бэлтгүүлэе. Үүнийг басхүү сайд жанжин ван танд явуулаад байцаан үзүүлсүгэй. Үүний тул өргөн тушаан илгээв. Олноо өргөгдсөний хоёрдугаар он, цагаан сарын арван есөн”

Эх сурвалж: МУУТА, Автономитын шинэ фонд. Эх бичиг. 6-31-39

1912 оны 04 дүгээр сарын 17-нд илгээсэн “Нийслэл хүрээний сургуульд явуулах хөвгүүд, дүү нарыг тодорхойлон Хан Хэнтий уулын чуулганд засаг бэйс нар-Мандахын хошуунаас өргөсөн бичиг”:

“Өргөх” бичиг

Бэйсийн зэрэг ахай засгийн улсад туслагч гүн Нармандах түшмэдийн бичиг. Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамны дэд сайд Хан Хэнтий уулын чуулганы дарга засаг цэцэн чин ван танаа өргөв. Мэдүүлэх учир. Эдүгээ сайд чуулганы дарга танай газраас Дотоод Яамнаас аливаа насан бага ван, гүн, засаг, тайж ба тэдний хөвгүүд дүү нарыг авч олон бичиг үсгийн сургуульд оруулж боловсруулах явдлыг айлтгаад Зарлиг ёсоор болгогтун гэснийг хичээнгүйлэн дагаж тушаан хүрч ирснийг сийрүүлэн өөр өөрийн харьяат ван, гүн, засаг, тайж мөн тэдний хөвгүүд дүү нарын дотроос арван наснаас дээш хорин нас үл хүрэх нь уг тушаасан ёсоор болзооны урьд нийслэл Хүрээнд илгээн одуулж сургуульд оруулахаас гадна, тэдний нэр, нас зэргийг тодорхойлон цэс үйлдэж хаврын сүүл сарын шинийн нэгэнд мэдүүлэн ирүүлэе гэх зэргээр тушаасан. Үүнд: бэйс Нармандах миний хөвгүүн тэргүүн зэрэг тайж Шагдаргочоо арван найман настай болохоос өөр хөвгүүн дүү наргүй тул цэс үйлдэж мэдүүлсэн явдлыг хамтаар гаргаж үүний тул өргөв. Олноо өргөгдсөний хоёрдугаар он. Хоёр сарын хорин долоон”

Эх сурвалж: МУУТА, Автономитын шинэ фонд. Эх бичиг. 6-31-39.

Тайлбарлах үг:

- Бэйс, олноо өргөгдсөний хоёрдугаар он

Эх сурвалж 4:

1917 оны 04 дүгээр сарын 05-нд гаргасан “Халх дөрвөн аймаг, хошуу шавийн газар байгуулагдсан 49 сургуулийн тухай” хэмээх түүхийн эх сурвалж:

“Өргөн тушаан илгээв

... Энэ завсар... цэцэн чин ван Гомбосүрэн, бэйс Сансрайдорж, Гомбосүрэн, гүн Дамдинжав, Засагт хан аймгийн ахай бэйс Цэрэндорж, Сайн ноён хан аймгийн цэцэн ван Няант, сайд далай чойнхор ван Цэдэнсодном, сайд ван Жамьяандорж, ван Гүргэмжав, бэйс Норовжамцан, бэйс Сандагдорж, Ядамжав, сайд түшээ гүн Цогт-Очир, Билбэбүү, Үржинжав, Товчинжамц, Лувсанхайдав, Дашдорж, Мөнх-Очир, Гончигчойнжин, Бариарагчаа, Пүрэвжав, Чүлтэм, зая бандид хутагт, наранхутагт,

хамбахутагт номун хан, эрдэнэ мэргэн ноён хутагт, шива ширээт хутагт, чин сүжигт номун хан нарын хошуу шавь дөчин есөн газраас бага сургуулийн танхим нээж байгуулсан зэрэг учрыг тус тус тодорхойлон гаргаж удаа дараа өргөн мэдүүлсэн... Үүний тулд өргөн тушааж илгээв. Олноо өргөгдсөний долдугаар он хоёрдугаар сарын арван дөрвөн”

Эх сурвалж: МУУТА, Автономитын шинэ фонд. Эх бичиг. 6-31-39

1915 онд гарсан бага ба дунд сургуулийн дүрмийн 4 дүгээр зүйлд дараах адил заалт оржээ. Үүнд: “Аливаа хан, ван, гүн, түшмэл, тайж ба баялаг ард ганц нэгэн хүн буюу эсвэл хэд хэдэн хүн хоршоолон нийлж, дуртайяа өөрийн хөрөнгөөр Нийслэл Хүрээ ба олон чуулган аймаг шавийн зэрэг газраа (бага) дунд зэргийн сургуулийн танхим тусгайлан байгуулж, хөвгүүд дүү нарыг олон зүйлийн эрдэмд сургасугай хэмээх нь буй аваас даруй өөр өөрийн харьяат дээд газраа мэдүүлээд уламжлан сургуулийн хэргийг захиран шийтгэх Яаманд тодорхойлон мэдүүлж тогтоосон дүрмийн ёсоор шийтгүүлэхээс гадна, өөрийн хөрөнгөөр сургуулийн танхим байгуулагсдыг сургуулийн хэргийг захиран шийтгэх Яамнаас зарлигийг гуйн айлтгаж хэтэрхийгээр сайшааж хөхүүлбээс зохимой”

Эх сурвалж: Монголын автономит үеийн сургууль, 1966, 21 дэх тал

Тайлбарлах үг:

- Олноо өргөгдсөний долдугаар он

Багшид зориулсан мэдээлэл:

НҮБ: Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW): НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 34/180 тоот тогтоолоор баталсан тус конвенц нь жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр гарсан эрх зүйн гол баримт бичиг бөгөөд энэ асуудлаар гарсан хожмын тогтоол, зөвлөмжүүдийн тулгуур баримт бичиг болсон юм. Энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор Конвенцийн хорооноос 1989, 1992 онуудад зөвлөмж, тогтоолууд гаргасан байдаг. Монгол Улс энэхүү Конвенцид 1981 онд нэгдэн орсон бөгөөд 4 жил тутам Конвенцийн хэрэгжилтийн талаар тайлан тавьж, хэлэлцүүлж ирсэн байна.

Венийн тунхаг бичиг: Австрийн Вена хотод 1993 оны 06 дугаар сарын 25-ны өдөр болсон Хүний эрхийн дэлхийн бага хурлаас эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь хүний эрхийн зөрчил болохыг тэмдэглэж, улмаар төгсгөлийн баримт бичиг болох “Венийн тунхаглал”-д нийгмийн болон гэр бүлийн харилцаанд эмэгтэйчүүдийг хүчирхийлэх бүх хэлбэрийг устгахын чухлыг онцлоод, улс гүрнүүдэд бэлгийн дарамт, мөлжлөг, жендэрийн тэгш бус байдлыг халахад чиглэсэн арга хэмжээ авахыг уриалсан байна. Энэхүү тунхаг бичгийн уриалгын дагуу Монгол Улс олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн бөгөөд НҮБ-ын тогтолцооны хүрээнд батлагдан гарсан хүний эрхийн гэрээ, конвенц, нэмэлт протоколуудад нэгдэн орох чухал хөшүүрэг болсон юм.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудал хариуцсан тусгай илтгэгч: НҮБ-ын Хүний эрхийн комисс 1994 онд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар ажиллах тусгай илтгэгчийг томилсон бөгөөд олон улсын эмэгтэйчүүдийн байгуул-

лагын шаардлагад үндэслэн гаргасан уг шийдвэр нь эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах салбарт гарсан томоохон ахиц дэвшилд тооцогддог.

Тусгай илтгэгчийн гол үүрэг нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдал дүн шинжилгээ хийж, жил бүр Женев дэх хүний эрхийн комисст танилцуулах явдал юм.

Эмэгтэйчүүдийг хүчирхийлэхийн эсрэг тунхаглал: НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1993 онд Эмэгтэйчүүдийг хүчирхийлэхийн эсрэг 6 зүйл бүхий тунхаглал гаргасан. Уг тунхаг бичгийн 4-р зүйлд эмэгтэйчүүдийг хүчирхийлэхийн эсрэг үндэсний хэмжээнд төлөвлөгөө гарган, холбогдох санхүүжилтийг шийдвэрлэн санаачилгатай ажиллахыг уриалсан байдаг.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага нь дэлхий нийтэд тулгамдсан эрүүл мэндийн асуудлыг тодорхойлох, судалгааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, стандарт нормуудыг боловсруулах, нотолгоонд суурилсан бодлогыг санал болгох, улс орнуудад техникийн дэмжлэг үзүүлэх, хяналт үнэлгээ явуулах үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг; НҮБ-ын Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн агентлаг юм. Тус байгууллагаас 1996 онд гэр бүлийн хүчирхийлэл нь нийгмийн эрүүл мэндийн салбарын нэн тулгамдсан асуудал болохыг онцлон тогтоол гаргаж 1997 онд хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх удирдамжийг баталсан билээ.^{128 129}

Жендэр ба хүйсийн тэгш байдлын тухай үзэл баримтлал: Жендэр бол улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлага юм.

Харин хүйс гэдэг бол эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн биологийн болон бие махбодын ялгаатай байдал юм. Хүйс нь биологийн ялгаатай байдал бөгөөд төрөлхийн, заяагдмал учраас хүн хүйсээ сонгож төрөх боломж байдаггүй. Тэгвэл жендэр нь энэхүү төрөлхийн өөрчлөгдөшгүй байдалтай холбоогүй, харин боловсрол, гэр бүл, сургууль, нийгэм, найз нөхөд болон биднийг хүрээлэн буй орчноос хамаарсан ойлголт юм. Жишээлбэл, хүүхэд хүйсийн хувьд эмэгтэй боловч өөрийгөө нийгэмд эрэгтэй хүнээр хүлээж авахыг хүсэж байвал түүнийг бид хүйсийн хувьд эмэгтэй боловч нийгмийн байр суурийг нь эрэгтэй хүний адил хүлээн зөвшөөрөх ёстой болдог.

Хүснэгт. Жендэр ба хүйсийн ялгаа

Жендэр	Хүйс
Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн үүрэг ялгаатай байдал өөрчлөгдөх боломжтой.	Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн биологийн болон физикийн ялгаатай талууд өөрчлөгдөшгүй.
Нийгэмд төлөвших явцад соёл, уламжлал, нийгмийн харилцааны нөлөөгөөр бий болдог	Төрөлхийн, байгалаас заяасан.
Бүс нутаг, түүхэн хугацааны явцад өөрчлөгддөг ойлголт.	Дэлхий дахинд ижил ойлголт

128 <http://www.legalinfo.mn/law/details/1285?lawid=1285>

129 <http://mn-nhrcc.gov.mn/hrd/ViennaDeclarationProgrammeActionBrochure.pdf>

Хүүхэд асрах үүргийг ихэвчлэн эмэгтэйд ногдуулах боловч заавал тийм байх ёстой гэсэн үг биш	Зөвхөн эмэгтэй хүн жирэмслэх, хүүхэд төрүүлэх боломжтой.
Эрэгтэй хүн тооцоолохдоо, эмэгтэй хүн мэдрэмжээрээ илүү	Эрэгтэй, эмэгтэй хүмүүс булчингийн масс, физик хүч чадлаараа ялгаатай.
Эрчүүд гэр бүлээ тэжээн тэтгэдэг	Эрчүүд сахал тавьдаг г.м

Жендэрийн хэвшмэл үзэл гэж юу вэ? Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлан тогтсон ялгаатай ойлголт, хандлагыг жендэрийн хэвшмэл үзэл гэдэг. Өөрөөр хэлбэл эрэгтэй учраас, эсвэл эмэгтэй учраас гэсэн шалтгаанаар тэдэнд ямар нэг онцгой үүрэг ногдуулдаг нь эрэгтэй болон эмэгтэй хүмүүсийн шинж чанар, байдал төрх, зохих үүргийн талаарх итгэл үнэмшил юм.

Хүснэгт. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн талаарх хэвшмэл үзэл

Эмэгтэйчүүдийн талаарх уламжлалт хандлага	Эрэгтэйчүүдийн талаарх уламжлалт үзэл
- Эмэгтэй хүний үс нь урт, ухаан нь богино;	- Өрхийн тэргүүн, гэрийн эзэн, ноён нуруу
- Оргүйгээс охинтой нь дээр;	- Эр муу ч эмийн дээр
- “Төрийн ажлыг эрчүүд цэгцэлж, гэрийн ажлыг эмэгтэйчүүд хийдэг”	- Эрэгтэй хүнийг амжилтад хүрэхэд өөрийг нь чадалтай, сайн гэж үнэлэх хандлагатай
- Эмэгтэй хүн амжилттай явахад хэн нэгэн тусалсан, эсхүл ямар нэг буруу аргаар энэ амжилтад хүрсэн гэж үзэх хандлагатай	- Идэвхтэй харилцаанд орох чадвартай эрэгтэй хүнийг нийтэч, наргианч, сэргэлэн г.м эерэг хандлагаар үнэлдэг г.м
- Харилцаанд идэвхтэй, санаачилгатай орох чадвартай эмэгтэй хүнийг аманцар, хэрүүлч, амбицтай г.м сөрөг хандлагаар үнэлдэг г.м	

Жендэрийн тэгш бус байдал: Аливаа стандарт, хэм хэмжээ, үйлдэл, эс үйлдэхгүй нь хүнийг эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэхийг жендэрийн тэгш бус байдалд хамааруулан авч үзнэ. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд “жендэрийн ялгаварлан гадуурхалт” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхгүйг” гэж заажээ.

Эрэгтэй болон эмэгтэй хүний ялгаа нь тэдний юуг чухал болон шийдвэрлэх ач холбогдолтой гэж үзэхээс үүдэлтэй байдаг. Аливаад хандах хандлага болон үйл ажиллагаа нь юуг бодит хүч гэж үздэгээс үүдсэн тэгш бус харилцаа үүсгэдэг. Ихэнх нийгэмд эмэгтэйчүүд эрчүүдээс сул дорой гэж үздэгээс эрх болон боломж нь хязгаарлагдмал байдаг. Энэ нь бидний бие махбодын ялгаа гэхээсээ нийгэм дэх тэгш бус хэм хэмжээ, нөхцөл, үнэт зүйлтэй холбоотой.

Хүйсийн тэгш байдал: Хүйсийн тэгш байдал гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажил мэргэжил болон хөгжих боломж тэгш байх тухай ойлголт юм. Тэгш байдал нь зөвхөн эмэгтэйчүүдийн эрх ашгийг хангах тухай ойлголт биш, харин аль аль хүйсийн ялгаваргүй байх тухай асуудал юм. Эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжил болон үнэт зүйлс зэрэг тэдний хүний эрхийг хангах тухай асуудал юм.

Монгол Улсын Үндсэн хууль 16 дугаар зүйл: 11/ улс төр, эдийн засаг, нийгэм соёлын

амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;

Жендэрийн тэгш байдлын тухай хууль: 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “жендэрийн эрх тэгш байдал” гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг”;

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчмууд:

- Жендэрийн тэгш эрхийн зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцөлийг хангах;
- Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх;
- Төрийн хариуцлагын зарчим: төр эрэгтэй, эмэгтэй хүний эрх тэгш байдлыг хангах талаар Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжоор ногдуулсан үүргээ биелүүлэх, түүний үр дүнгийн төлөө хариуцлага хүлээх;
- Жендэрийн мэдрэмжтэй бодлогын зарчим: хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөлд жендэрийн үзэл баримтлалыг тусгах замаар хөгжлийн бодлогыг жендэрийн агуулгатай болгох;
- Жендэрийн мэдээлэл хүртээмжтэй байх зарчим: хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангах.

4.5.3. Суурь боловсролын нийгэм судлалын хичээл

4.5.3.А. ТХБ-д суурь боловсролын нийгэм судлалын хичээлээр оруулах хувь нэмэр

ЕБС-ийн VIII-IX ангид нийгмийн ухааны хичээлийг судалснаар сурагчид “Нийгмийн шинжлэх ухааны хэл болон шинжлэн судлах, танин мэдэхүүд суралцан, хамтран ажиллах чадвартай, ардчиллын үнэт зүйлсийг эрхэмлэгч, бүтээгч иргэн” болж төлөвших юм. Сурагчид нийгмийн шинжлэх ухааныг судлах явцдаа:

- Идэвхтэй бүтээлч, эрэл хайгуул хийх замаар нийгмийн үйл явдал, үзэгдлийг шинжлэн судлах;
- Нийгэмд болж буй үйл явдал, үзэгдлийн талаар өөрийн байр, суурь үзэл бодлоо илэрхийлэх, тайлбарлах;
- Өөрийн орон нутаг, хүрээлэн буй орчин, бодит амьдрал, үйл ажиллагаанд тулгарч буй асуудал бэрхшээлийг шийдэх арга, хувилбарыг дэвшүүлэх;
- Ардчиллын үнэт зүйлийг эрхэмлэн, эрх, үүрэг, хариуцлагаа ухамсарлах

зэрэг тухайлан нийгмийн ухааны сургалтаар эзэмших тусгай чадвараа хөгжүүлж байдаг.

Сурагчид нийгмийн ухааны хичээлээр дээр тэмдэглэсэн чадварыг хөгжүүлснээр ТХБ-д тус хичээлийн оруулах хувь нэмэр хангагдах юм.

Суурь боловсролын нийгмийн ухааны сургалтын цөм хөтөлбөрийн¹³⁰ агуулга (суралцахуйн зорилт) болон ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, ТХЗ-д хүргэх санал болгож буй сэдэв бүрийг холбогдох байдлаар нь шинжилснийг өмнө танилцуулсан бөгөөд шинжилгээний үр дүнгээс харахад ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, санал болгож буй сэдэвтэй уялдаж болох цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт 12 байгаа бөгөөд тэдгээр нь тогтвортой хөгжлийн 10 зорилт, ТХЗ-д хамаарах 14 суралцахуйн зорилт, сэдэвтэй уялдаж байсан билээ. Эндээс бид суурь боловсролын нийгмийн ухааны сургалтын цөм хөтөлбөрийн зарим агуулга, суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд сурагчид тогтвортой хөгжлийн талаарх ойлголт, мэдлэгээ гүнзгийрүүлж, тогтвортой хөгжлийн боловсролын тодорхой чадвар, чадамжид суралцах боломжтой гэсэн дүгнэлт хийсэн.

Нийгмийн ухааны суралцахуйн зорилтыг ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, санал болгож буй сэдэвтэй уялдуулж хэрэгжүүлснээр сурагчдад ТХБ-ын цогц чадамжийг хөгжүүлэхэд тодорхой хэмжээгээр дэмжлэг, хувь нэмэр болж байна. Ялангуяа, шүүмжлэлт сэтгэлгээ, хамтран ажиллах, өөрийгөө танин мэдэх, хэм хэмжээний цогц чадамжийг хөгжүүлэхэд илүү хувь нэмрээ оруулах боломжтой байна. Сурагчдын эдгээр цогц чадамжийг хөгжүүлснээр орон нутаг, улс үндэстэн цаашлаад дэлхий нийтийн ТХ-ийн зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр болох ач холбогдолтой юм.

Хүснэгт. Нийгмийн ухааны хичээлд ашиглах ТХЗ-ыг хангах сургалтын арга

№	Бүлэг арга	Тайлбар
1	Бодит үйл ажиллагаанд оролцох	Эдгээр нь нийгмийн ухааны хичээлийн шинжлэн судлах арга барилыг эзэмшүүлэх нийтлэг аргууд бөгөөд судалгаа, шинжилгээ хийх аргыг орон нутгийн нийгэм, эдийн засагтай холбоотой асуудлыг тодорхойлоход, бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх аргыг кейс, тохиолдол шинжлэхэд, бодит үйл ажиллагаанд оролцох аргыг нийгмийн ухааны хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадвараа амьдрал, практикт хэрэгжүүлэн асуудлаа шийдвэрлэхэд түлхүү ашиглаж байна.
2	Шинжилгээ/ судалгаа хийх	
3	Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх	
4	Алсын хараатай болох	

Энэхүү шинжилгээг хийхдээ цөм хөтөлбөрийн агуулга (суралцахуйн зорилт) нь үзэл санаа, агуулга, эзэмшүүлэх чадвараараа ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, сэдэвтэй хэрхэн уялдаж байгаад анхаарсан болохыг энд тэмдэглэж байна.

130 БСШУ-ны сайдын тушаал А/302., 2016.07.10, нэгдүгээр хавсралт., БСШУ-ны сайдын тушаал А/277, 2016.06.27

4. Хүний эрхийн үндэстэн, үндэстэний эрхийн эрх ба хууль	<p>Агуулга:</p> <p>Хүний эрхийн зөрчил, түүнтэй холбогдох эрх зүйн хамгаалал, зөрчилтийн үндэстэн, үндэстэн мэддэг үзэх гүнзгийрүүлэх Тодруулан авч үзэх: Сурагч өөрийн орон нутгийн ард, иргэдийн газар өмчлөх эрхээ хэрхэн эдэлж байгааг шинжлэх, газраа өмчлөх авч үзэх, газраа эрхэлж байгааг хэрхэн эрхэлж байгааг тэдэнд хэрхэн нөлөөлж байгааг хамраарх хууль дүрэм, журамтай холбон танилбарлах замаар хүний эрхийн зөрчллийг ялган таныж, хариуцаж уулиар таныг эдэлж хамгаалах чадварыг суралцана.</p>	<p>Орон нутгийн иргэдийн хуулиар олгогдсон эрхээ хэрхэн эдэлж буйд дүн шинжилгээ хийн эрх зөрчилдөж буй хүмүүсийн эрхийг хариуцаж уулиар таныг эдэлж хамгаалах замаар шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамжаа хөгжүүлнэ.</p>
TX310.СЭ03	<p>Сурагч өөрийн орон нутгийн ард, иргэд, айл өрхийн хуулиар олгогдсон эрхээ хэрхэн эдэлж байгааг шинжлэх, газраа өмчлөх авч үзэх, газраа эрхэлж байгааг тэдэнд хэрхэн нөлөөлж байгааг хамраарх хууль дүрэм, журамтай холбон танилцуулах, зөвлөлөө өгөх журмыг танилцуулах, зөвлөлөө өгөх</p>	<p>Сурч боловсрох эрхээ эдлэн сайн боловсрол эзэмшсэнээр нь хуулиар олгогдсон эрхээ хэрхэн эдэлж хамгаалах замаар шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамжаа хөгжүүлнэ.</p>
TX310.ЭҮЭ	<p>Агуулга:</p> <p>Хүний эрх, эрх-үрэг, хүний эрхийн хамгаалал, зэргийг үргэлжлэн эдгээ эдлэн суралцаж Тодруулан авч үзэх: Сурч боловсрох эрхээ эдлэн сайн боловсрол эзэмшсэнээр бусад эрхээ эдлэх мэдлэг чадвартай болж, сайхан амьдрах багалтаа болохыг ойлгох</p>	<p>Сурч боловсрох эрхээ эдлэн сайн боловсрол эзэмшсэнээр нь хуулиар олгогдсон эрхээ хэрхэн эдэлж хамгаалах замаар шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамжаа хөгжүүлнэ.</p>
TX304.ТМ2	<p>Сурч боловсрох эрхээ эдлэн сайн боловсрол эзэмшсэнээр бусад эрхээ эдлэх мэдлэг чадвартай болж, сайхан амьдрах багалтаа болохыг ойлгох</p>	<p>Сурч боловсрох эрхээ эдлэн сайн боловсрол эзэмшсэнээр нь хуулиар олгогдсон эрхээ хэрхэн эдэлж хамгаалах замаар шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамжаа хөгжүүлнэ.</p>
TX304.СЭ01	<p>Сурч боловсрох эрхээ эдлэн сайн боловсрол эзэмшсэнээр бусад эрхээ эдлэх мэдлэг чадвартай болж, сайхан амьдрах багалтаа болохыг ойлгох</p>	<p>Сурч боловсрох эрхээ эдлэн сайн боловсрол эзэмшсэнээр нь хуулиар олгогдсон эрхээ хэрхэн эдэлж хамгаалах замаар шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамжаа хөгжүүлнэ.</p>
	<p>Сурч боловсрох эрхээ эдлэн сайн боловсрол эзэмшсэнээр бусад эрхээ эдлэх мэдлэг чадвартай болж, сайхан амьдрах багалтаа болохыг ойлгох</p>	<p>Сурч боловсрох эрхээ эдлэн сайн боловсрол эзэмшсэнээр нь хуулиар олгогдсон эрхээ хэрхэн эдэлж хамгаалах замаар шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамжаа хөгжүүлнэ.</p>

4.5.3.Б. Нэгж хичээлийн жишээ

Сэдэв: “Соёл ба тогтвортой хөгжил”

Сэдэв сонгосон үндэслэл, багшид зориулсан тэмдэглэл

Суурь боловсролын IX ангийн нийгмийн ухааны хичээлийн “Хувь хүн ба соёл” агуулгын хүрээнд судлах “Соёл бол үнэт зүйлсийн тогтолцоо мөн” сэдэвтэй ТХ-ийн 4-р зорилгын (ТХ304.ТМ4) “Сурагч нь тогтвортой байдалд хүрэхэд соёл чухал үүрэгтэйг ойлгодог болох” суралцахуйн зорилт болон ТХ3-д хүргэх санал болгож буй (ТХ304.СЭ08) “Тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд шаардагдах мэдлэг, чадвар, үнэт зүйлс ба зан үйл” сэдэвтэй уялдаж байна. Тухайлбал,

- “Соёл хүний хоёр дахь төрөлт болох нь” сэдвийн хүрээнд соёлын олон төрөл, тэдгээрийн харилцан нөлөөлөл, өөрчлөлт нь хүний амьдрал ахуй, улс орны хөгжилд хэрхэн нөлөөлдөг талаар таамаглал дэвшүүлэн судалж, өөрийн үнэлэлт дүгнэлт өгөх замаар тогтвортой байдалд хүрэхэд соёл чухал үүрэгтэйг ойлгоно.
- “Соёл бол үнэт зүйлсийн тогтолцоо мөн” сэдвийн хүрээнд уламжлалт соёлын үнэт зүйлс, зан үйлүүд нь тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжиж байдгийг ухааран тэдгээрийг хүндэтгэх, өвлөх, дээдлэх хүсэл эрмэлзлэл төрүүлэхэд чиглэнэ.

Нийгмийн ухааны хичээлийн үндсэн агуулга, арга зүйг алдагдуулахгүйгээр дээрх 2 сэдвийг тогтвортой хөгжлийн асуудлаар баяжуулсан “Соёл ба тогтвортой хөгжил” нэгж хичээлийн үлгэрчилсэн төлөвлөлтийг та бүхэнд санал болгож байна.

Хүснэгт. Сонгосон зорилт ба сэдэв

Зорилт		Сэдэв	
Цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт:	ТХ3-д хамаарах суралцахуйн зорилт:	Судлагдахууны сэдэв:	ТХ3-д хүргэх санал болгож буй сэдэв:
Соёл бол үнэт зүйлсийн тогтолцоо болохыг ухааран ойлгож хүндэтгэх, дээдлэх, өвлөх үүргээ ойлгох хүсэл эрмэлзэлтэй болно.	(ТХ304.ТМ4) Сурагч нь тогтвортой байдалд хүрэхэд соёл чухал үүрэгтэйг ойлгодог болох	<ul style="list-style-type: none"> “Соёл хүний хоёр дахь төрөлт болох нь” Соёл бол үнэт зүйлсийн тогтолцоо мөн 	(ТХ304.СЭ08) Тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд шаардагдах мэдлэг, чадвар, үнэт зүйлс ба зан үйл

Арга зүйн сонголт ба цогц чадамж: Тус хичээлийг шинжлэх судлах аргаас гадна бүтээлч шүүмжлэлт сэтгэлгээ, бодит үйл ажиллагаанд оролцох, алсын хараатай болох зэрэг аргаар зохион байгуулахаар төлөвлөсөн болно. Эдгээр аргыг ашиглан дараах даалгавар, үйл ажиллагааг хэрэгжүүлж болох юм. Үүнд:

- “Соёл, соёлын олон төрөл, үнэт зүйлс” зэрэгтэй холбоотой ойлголт, мэдлэгээ ашиглан хүний хөгжил төлөвшил болон улс орны тогтвортой хөгжилд үзүүлэх нөлөө, хамаарлыг шинжлэн хэлэлцэх,
- Өөрийн соёлын хандлага, үйл хөдлөлөө эргэцүүлэн шүүмжлэлтэй хандах,
- Байгаль, нийгэмд ээлтэй уламжлалт соёл, зан үйлийг хүндэтгэн өвлөх, хадгалах талаар сурталчлах,
- Орон нутгийн ард иргэдийг уриалах зэрэг бодит үйл ажиллагааг зохион байгуулах гэх мэт.

Орчин үед уламжлалт соёл, зан үйл алдагдсанаар байгаль, нийгэмд үзүүлж буй үр дагавар, хор хөнөөл ихсэж байгаад шүүмжлэлтэй хандан хэлэлцэх үйл ажиллагаанд сурагч идэвх санаачилгатай оролцсоноор тогтвортой хөгжлийн

“шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж”, өөрийнхөө соёлын хандлага, үнэлэмж, ойлголт, үйл хөдлөлөө эргэцүүлэн өөртөө дүгнэлт хийснээр “өөрийгөө таньж мэдэх” цогц чадамжаа хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах юм.

Нэгжийн хичээлийн төлөвлөлт:

Нэгж хичээлийн зорилго:

Соёл хийгээд тогтвортой хөгжлийн харилцан хамаарлыг ойлгох, соёлын үнэт зүйлсээ хайрлан хамгаалах, өвлөх сэдэл тэмүүлэлтэй болох

Анги: IX

Хугацаа: 4 цаг буюу 160 минут

Хичээлийн үндсэн агуулга:

Соёлын олон төрөл, тэдгээрийн харилцан нөлөөлөл, өөрчлөлтийг шинжлэн судалж, соёлын олон янзын нөхцөлд зохицон амьдрах чадвараа нэмэгдүүлэх, хүний амьдралд соёл ямар чухал зүйл болохыг ухаарч ойлгох, түүнчлэн соёлын үнэт зүйлсийг тодорхойлон тэдгээрийг хүндэтгэх, хадгалах, өвлөх итгэл үнэмшилтэй болоход чиглэнэ. Үүний тулд:

- Соёлын тухай янз бүрийн тодорхойлолтыг уншин ярилцах
- Соёлын үнэт зүйлсийг тодорхойлох /эдийн болон эдийн бус/ Үүнд: өөрийн орон нутгийн соёлын үнэт зүйлсийг авч үзэх
- Соёлын олон төрөл тэдгээрийн харилцан нөлөөлөл, өөрчлөлтийг харуулсан кейс, тохиолдол шинжлэх
- Өөрийнхөө болон бусдын соёлын хандлага, зан үйлийг эргэцүүлж, шүүмжлэлтэй хандан хэлэлцэх
- Хүн төрөлхтний болон монгол уламжлалт соёл тэр дундаа өөрийн орон нутгийн соёлын үнэт зүйлсээ хайрлах, хамгаалах, хүндлэн дээдлэх, өвлөх талаар эсээ, илтгэл бичих, танилцуулах, бусдад уриалах гэх мэт

Арга зүй:

- Шинжлэн судлах арга
- Шүүмжлэлт сэтгэлгээний арга
- Бодит үйл ажиллагаанд оролцох

Тогтвортой хөгжилтэй холбох боломж, хувилбар

- Тогтвортой хөгжил (байгаль, нийгэм, эдийн засагт)-д ээлтэй уламжлалт соёл, ёс заншлын талаар судлах. Тухайлбал: байгальтай харилцах уламжлалт ёс заншлын талаар байж болно.
- Цуглуулсан мэдээлэлдээ дүн шинжилгээ хийж тэдгээрийн хүний хөгжил, төлөвшил болон улс орны тогтвортой хөгжил (байгаль, нийгэм, эдийн засагт)-д үзүүлэх нөлөө, хамаарлыг илрүүлэх.
- Өөрийнхөө соёлын хандлага, үйл хөдлөлөө эргэцүүлэх.
- Байгаль, нийгэмд ээлтэй уламжлалт соёл, зан үйлийг хүндэтгэн өвлөх, хадгалах талаар сурталчлах, орон нутгийн ард иргэдийг уриалах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах замаар соёл нь тогтвортой хөгжилд хэрхэн нөлөөлдөг болохыг ойлгож, холбогдох уламжлалт заншил, зан үйлүүдийг өвлөх, хамгаалах сэдэл тэмүүллийг бий болгох боломжтой юм.

Тэмдэглэл, анхаарах зүйл:

- Холбогдох сэдвийн хүрээнд дээрх санал болгож буй хувилбараар агуулгыг баяжуулан хэрэгжүүлэхэд багш анхаарлаа хандуулах бөгөөд анги, сурагчийн онцлог болон орон нутгийн соёл, уламжлал ёс заншлыг харгалзан үзэх нь зүйтэй.
- Доор санал болгож буй үйл ажиллагаа нь тогтвортой хөгжлийн зорилт, сэдэвтэй уялдуулах боломжит хувилбар бөгөөд хичээлийн үндсэн агуулгыг аль хэсэгт нь хэрэгжүүлэхийг багш шийднэ.
- Тогтвортой хөгжлийн талаар сурагчдад тайлбарласны дараа энэхүү даалгаврыг хийж гүйцэтгэнэ.
- Хичээлийн хэрэглэгдэхүүн (холбогдох видео, фото зураг, үзүүлэн, кейс, тохиолдол, ном гарын авлага)-ийг доорх үйл ажиллагааны агуулга, зорилгод нийцүүлэн багш өөрийн нөөц боломждоо тулгуурлан бэлтгэж хичээлд ашиглана.

Үйл ажиллагаа 1. Тогтвортой хөгжил (байгаль, нийгэм, эдийн засагт)-д нөлөөлөл ээлтэй уламжлалт соёл, ёс заншлын талаар судлах

Алхам 1. Байгальтай харилцах, хамгаалах уламжлалт соёл, ёс заншлын талаар мэдээлэл цуглуулах

- Соёл, ёс заншлын талаарх ном, гарын авлага унших,
- Ахмад хүмүүстэй уулзалт ярилцлага хийх,
- Орон нутгийн байгаль хамгаалах газар болон холбогдох хүмүүсээс сурвалжилга хийх.

Алхам 2. Жижиг бүлгээр ажиллан цуглуулсан мэдээллээ доорх хүснэгтэд нэгтгэж, асуултын дагуу ярилцана уу.

Уул, овоо, хайрхантай холбоотой	Ус гол мөрөнтэй холбоотой	Ургамал, хөрс шороотой холбоотой
.....
.....
.....

Эдгээр уламжлалт ёс заншлын талаар хүмүүс хэр мэдэж, хүндэтгэн өвлөн хадгалж байгаа гэж үзэж байна вэ?

- Уламжлалт ёс заншил нь соёлын аль төрөлд хамаарах вэ?
- Эдгээр нь соёлын үнэт зүйлс мөн үү? Яагаад?
- Эдгээр ёс заншлыг та бүхэн хэр мэдэж, хэрэгжүүлдэг вэ?

Үйл ажиллагаа 2. Тохиолдол шинжлэх (Шүүмжлэлт сэтгэлгээний аргаар)

Зохион байгуулалт:

- Сурагчдыг 3 багт хуваана.
- Доор өгсөн чиглэлийг баг тус бүрд хуваарилна.
 - Уул, овоо, хайрхантай холбоотой;
 - Ус гол мөрөнтэй холбоотой;
 - Ургамал, хөрс, шороотой холбоотой;

Алхам 1. Багууд хуваарилагдсан чиглэлтэй холбоотой ёс заншил алдагдаж байгаа бодит жишээ, кейс, тохиолдол нэгийг ярилцаж гаргана.

Алхам 2. Гаргасан жишээ, тохиолдлоо тогтвортой хөгжлийн үүднээс шинжилж, хэлэлцэнэ.

- Орчин үед уламжлалт соёл, ёс заншил алдагдсанаар байгаль орчинд ямар сөрөг нөлөө үзүүлж байна вэ?
- Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө нь өөр бусад зүйлд хэрхэн нөлөөлөх бол? Тухайлбал:
 - Хүүхдийн хүмүүжил төлөвшил,
 - Хүмүүсийн амьдрал,
 - Улс орны эдийн засаг,
 - Нийгмийн хөгжилд хэрхэн нөлөөлж байгаа талаар жишээ баримтаар тайлбарлах
- Соёл, ёс заншлаа хадгалан, өвлүүлэхийн тулд та юу хийж чадах вэ?

Тэмдэглэл, анхаарах зүйл:

Багш сурагчдын хариултад үндэслэн асуултыг дэлгэрүүлж, тодруулах (яагаад, ямар учраас...) боломжтой ба эдгээр уламжлалт, ёс заншил нь хичээлийн үндсэн агуулга болох соёлын үнэт зүйлсийн нэг хэсэг бөгөөд хүн бүр соёл, ёс заншлаа дээдлэн хүндэтгэж хэрэгжүүлэх нь улс орны тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулдаг болохыг тайлбарлана. Мөн тохиолдол шинжлэх явцад сурагчдын тогтвортой байдлын шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамжийг хөгжүүлэхэд анхаарч асуудалд шүүмжлэлтэй хандан түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар санаа бодлыг сонсохыг зорино.

Үйл ажиллагаа 3. Дүгнэлт-үнэлгээ

Алхам 1. “Бидний соёл, ёс заншил-бидний амьдралд” сэдэвт эсээ бичлэгийн уралдаан зарлаж, шалгаруулах

Эсээ дүгнэх шалгуур:

- Агуулга, ухагдахууны талаарх ойлголт, мэдлэг /соёл, үнэт зүйл, ёс заншил/-25 оноо
- Гол санаа /Соёл ба тогтвортой хөгжлийн харилцан хамаарал, нөлөөллийг гаргасан байдал/-30 оноо
- Дүгнэлт /өөртөө тавьсан зорилго, шинэ шийдэл/-25 оноо
- Найруулга, үг үсгийн алдаа-10 оноо
- Үгийн тоо-10 оноо

Алхам 2. Анги хамт олноороо хамтран байгаль, нийгэмд ээлтэй уламжлалт соёл, зан үйлийг хүндэтгэн өвлөх, хадгалах талаар сурталчлах, орон нутгийн ард иргэдийг уриалах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, гарч буй үр дүнг ажиглан дүгнэх

Хичээлийн нэмэлт хэрэглэгдэхүүн:

Байгаль хамгаалах ёс уламжлал

Н.Нагаанбуу, Н.Маралмаа нар.,

Монгол төрийн ёс заншлын үндэс номоос

Байгаль шүтлэг бол монголчуудын үндсэн сүсэг бишрэл мөн бөгөөд түүнийгээ ёс заншил болгон хамгаалж ирсэн түүхтэй. Эртний отог овог аймгууд уугуул нутаг, угаасан усаа шүтэн биширч таван тансаг идээний дээжээр тахиж цагаан сүүний

сацлаа өргөн хүндлэх зэргээр сэтгэл итгэлийн ариун дээд бүхнээ зориулж иржээ. Энэ бүхэн нь мухар сүсгийн бус байгалын хөгжлийн зүй тогтол жам хуулийг танин мэдсэний үр дүн гэж үзэх нь үнэнд нийцэх бөгөөд байгальд халгүй хөгжлийг эрхэмлэсэн нүүдэлч соёлын нэгэн гайхамшиг ухаан хэмээн үзвээс зохилтой ажээ. Монгол хүн болоод байгалийн хооронд тэрслүү түүх үгүй бөгөөд харин нөхөн сэргээх, өсгөн үржүүлэхэд чиглэсэн арвин баялаг уламжлал бүрджээ. Жишээ нь: 1206 оны “Их засаг”-т “хэн ус руу шээвээс, гал алдаж бэлчээр шатааваас, өвс ургасан хойно газар нүхэлбээс цаазална /яллана/” гэж заасан нь дээрх дүгнэлтийг тодруулсан чухал сурвалж болно. “Монголчууд эрт цагаас нааш түүхийн урт хугацааны турш тэнгэр цэг, газар эх хэмээн ярилцаж, тэнгэрийн нар сар од гарагийн хамтад, газрыг хөрс шороо уул ус ургамал амьтны нь хамтад ухааран ойлгож тэд бүхнийг нийлбэр цогцсоор нь хүндлэн шүтэж биширч ирсэн түүхэн уламжлалтай” /О.Амархүү “Байгаль орчныг хамгаалах монгол ёс заншил, хууль цааз” УБ 2002 он/ гэсэн нь оновчтой дүгнэлт бөгөөд түүний тэмдгийн соёл дохионы эрэлт нь тэнгэр лус газрын овоо тахилга юм. Ерөөс монгол хүний, монгол төрийн хамгийн эрхэм дээд баяр нь “Дөрвөн улирлын тахилга” байсан нь түүний баталгаа болно.

Бурхан халдун чамайг
Өглөө бүр мялааж байя
Өдөр бүр тахиж байя
Үрийн үрд үүрд тахиж
Үе тутам үргэлж шүтэе.

/Тэмүүжин малгайгаа гарт сэгэлдэрч, гараар өвчүүгээ дарж наран өөд андаж есөнтөө сөгдөж өчил өчин сацал сацсан үг. МНТ-н103/

1. Цай, сүү, айраг сархад идээний дээжийг уул хайрхан, хангай дэлхийдээ өргөдөг нь дэлхий газар эхийг хүндлэн тахиж байгаа зүглэ тахилгын хэлбэр болно.
2. Булаг шандны эх, нуур цөөрөм гол усанд цус, сүү болон бусад элдэв зүйл оруулахыг чандлан цээрлэдэг нь усны найрлага чанар бузардахаас сэрэмжилсэн хэрэг бөгөөд хориг нь “хотонд чоно орно”, “биед яр гарна” гэх мэт айдаст зүйл болой.
3. Тогтмол цээл усанд бие, хувцас хунар угаах, тэнгэр харуулан угаасан зүйлээ дэлгэн хатаахыг цээрлэнэ. Эдгээр заалт “Их засаг” ёсноо хуульчлагдсан /1205 он/ бөгөөд энэ учрыг үл ухах гадаадын жуулчид /В.Рубрик, П.Карпино зэрэг/ Монголчууд усанд ордоггүй, юмаа угаадаггүй гэх мэтээр бичсэн нь буй. Эртний хэв хуулиас эхлээд угаасан зүйлээ гадны хүнд дэлгэн үзүүлэх зэргийг ийн хориглон цээрлэдэг тул хүний бараанаар хэцлэсэн хувцас зэргээ авч нуудаг заншилтай. Эртний үгэнд “Бүгдээр хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй” /МНТ/ гэх мэтээр хэлэлцдэг нь гол ус нуурт бус, тусгай сав суулганд угаал хийдэг асны нэгэн нотлол болно.
4. Газар ухах, шороо төнхөх, мод огтлохыг зөрчвөл газрын судас тасарч хөрс шархлан шанална хэмээн амьтанчлан үздэг. Онцгой ганц мод /удган/, оорцог хад хясаа зэрэг нь газрын судасны эх байдаг тул нэн нандигнаж бишрэн шүтдэг. Газрын судас байдаг нь нэгэнт батлагджээ. Түүнийг хөндсөнөөр сүүлийн үед олон булаг шанд гол горхи ширгэв.
5. Газарт гадас шон хатгаж орхих, нүүхдээ бууриа бохир үлдээхийг цээрлэдэг. Мөн

гадас хатгахдаа өдөр үзэж өчиг хэлж гуйж үйлддэг бол буцааж гадас шонгоо авахдаа заавал нүхийг бөглөдөг дэлхийн аминд нигүүлсэнгүй заншилтай авай. Хог үнс хаях газрыг бух тошиж шороо хөрсийг нь ухаж хөндсөн хэсгийг сонгон авдаг нь үнс уг газрыг бордоожуулж ургамалжуулдгаас үүдсэн санаа гэдэг.

6. Мод бут, цэцэг жимс ногоорч цэцэглэж байх үед огтлох хугалахыг, зулзаган ургамал гэмтээхийг хатуу цээрлэнэ. Энэ ёсоо хэрэгжүүлэхдээ лусын хорлол болно, лус савдаг, навдаг савдаг хилэгнэж амь насанд цөв дэв болно гэж эмээх айх дүр бүтээсэн гэдэг.
7. Алтан гадас одны зүг харж гадаалах /морь харах/-ыг цээрлэнэ. Энэ нь одот тэнгэрийг шүтсэн хүндлэл бөгөөд учир нь алтан гадас бүх оддын эх дэс ажээ
8. Ан амьтны нялх төл, нас бие үс гүйцээгүй араатан амьтныг агнах хороохыг, үргээж хөнөөхийг цээрлэнэ. Зөрчвөөс ан авын тэнгэр хаяж, хангай дэлхий хийгээ хорьж, навдаг савдаг ааш буруулна, араатан гөрөөс дайжна хомсдоно гэнэ.
9. Ан амьтныг ална гэх мэтээр ам гарахыг цээрлэнэ. Уг ан амьтанд бариулах, осолдох зэрэг сөрөг нөлөө үүсч гарсан ам, хэлсэн үг гэмтэнэ гэнэ.
10. Дуу цахилгаантай бороо орох үед айраг бүлэх /аянга бууна/, моринд хазаар зүүх /аянга дайрна/, мал саах /тэнгэрийн дуунд чимээ нь харшилна/, толгой нүцгэн явах /айдас аянга дуудна/, гүйж уралдах /аянга ниргэнэ/, хөлстэй морь унах, дэргэд нь зогсох /аянга дөтөлнө/ зэрэг цээртэй байдаг.
11. Зуны нар буцахаас өмнө /06 сарын 22/ урсгал усанд орохыг цээрлэнэ. Усны хор харшаа гараагүй тул өвчин олно, өрөөл татанхай болно гэнэ.
12. Хөлдүү газар, хүйтэн чулуун дээр суух /шамбарамтай болно/, удган модны хар сүүдэрт суух /лусын хорлолоор өвчин олно/, хуй салхинд дайрагдах /сүнс зайлна, саа тусна/ гэнэ.
13. Ялаа шумуулаас эхлээд ямарваа амьтан бирд рүү үлээх зэргээр амьсгалаа авхуулахыг цээрлэнэ. Амины гол үйл амьсгалаар амины гал хийгээд сүнс уг амьтанд шилжин хулжина гэж эмээн цээрлэнэ.
14. Бургас модыг монгол мод хэмээн шүтэх тул хугачих гишгэхийг цээрлэнэ. Уул давааны оройд босгосон овоод бургас хатган залам хэмээн нэрлэж дээдэлнэ. Бурхан халдун уул гэсэн нэр бургас модны онгон шүтээнт уул гэсэн утга санаа гэдэг.
15. Тэнгэр, лус, овоо тахилга: нэн эрт дээр үеэс Монголчуудын шүтлэг бишрэлийн гол цөм нь овоо тахилга байв. Овоо нь дотроо олон төрөл бөгөөд жишээ нь, 5 овоо, 13 овоо, 49 овоо зэрэг нь хар цагаан тэнгэр шүтлэгтэй, 81 овоо нь 99 тэнгэрийн дунд тэв газар дэлхийн хайрхдын шүтлэгтэй, 9 овоо нь доод тэв лус савдагтай холбоотой тул хамгийн гол шүтлэг болой. Овоо тахилгад цусаар тахих, сацал хийх зүглэ тайлга, галын тахилга гэх мэт олон янз бөгөөд овоог шашны сүм ойлголт номлолын төв хэмээн үзэх, бас нутаг орны хил хязгаарын тэмдэг зэргээр олон хэлбэр давхар зориулалттай байсан гэдэг.

Байгаль орчноо хайрлан хамгаалж ирсэн монгол уламжлал

“Монголчуудын цээрлэх ёс” хэмээх номоос

3-8 насны хүүхдэд “гал гаргаж тогловол зуд болдог,” “галд давс, ус бохир зүйл хийвэл нүд нь өвддөг”, эсвэл “нүүр амаар нь яр гардаг” гэх зэргээр багаас нь тэнгэр бурхан, байгаль дэлхийг дээдлэн шүтэх үзлийг төлөвшүүлэхэд чиглүүлж байсан тухай өгүүлжээ.

- Аливаа үйлийг хийхдээ нар зөв эргэх,
- Аянга цахилгааны үед анхаарал болгоомжтой байлгахын тулд нэг гэрт байгаа хүмүүс бүгдээрээ хэвтэж болохгүй, шагай тоглодоггүй,
- Газар шороог зорилгогүй ухдаггүй,
- Уул овоон дээрээс юм авдаггүй,
- Усанд бохир зүйл хийдэггүй,
- Амьтны үр төл дээр сүүдрээ тусгадаггүй,
- “Ална хядна” гэх зэрэг билэг дэмбэрэлгүй үг хэлдэггүй,
- Ургамал ногоог зүй бусаар зулгаадаггүй,
- Жимсийг мөчиртэй нь түүдэггүй, хэрэв ингэвэл дараагийн жил дахин ургаж үр шимээ өгөхгүй зэргээр хайрлан хамгаалах ухамсрыг төрүүлсээр иржээ.

9-12 насны хүүхдэд: Үнс асгуулах, аргал түүлгэх зэрэг ажил хийлгэж, тэнгэрийг бишрэн шүтэх ухамсрыг төрүүлэхийн тулд:

- Шинэдийн сарыг харвал нүдэнд сайн,
- Алтан гадас, долоон бурханд залбирвал хүсэл нь биелнэ,
- Уул овоонд чулуу өргөхдөө ерөөлийн үг хэлбэл үйлс нь бүтнэ,
- Алс хол газар явахдаа угаасан уснаасаа амсвал элдэв муу зүйл тохиолдохгүй, уул ус нь харж хандана гэж байгалийг бишрэн шүтэх ухамсрыг гүнзгийрүүлж өгдөг.

13-18 насны хүүхдэд:

- Дээлийн шилбэ, товчийг хадаад галд ариутгах, мал тамгалах аргыг зааж, догшин уул хад руу гэрийнхээ үүдийг голлуулж барьдаггүй,
- Бохирдсон худаг усыг ариутгах, бохирдуулахгүй байх аргад суралцах,
- Нүүдлийн шувууд, нүүдэлчин амьтад ирэхэд сааль сүүнийхээ дээжийг өргөж хурайлах,
- Ургаа мод аваад дээр нь шороо асгаж үндсийг нь хамгаалах зэргээр байгальтай харьцах зан үйлийг төгс эзэмшсэн байх ёстой ажээ.

18 ба түүнээс дээш насныханд:

- Гал тахихтай холбоотой үйлүүд, Долоон бурхны даллага авах, уул, овоо тахилгатай холбоотой зан үйл, худаг ус гаргах, түүний зан үйл, амьтныг хамгаалах үүднээс анчин хүний 108 цээрийг мэдэх зэрэгт суралцуулсаар иржээ. Ингэснээр байгаль хамгаалах зан үйлийн 30 орчим хувийг эзэмшдэг байна. Мөн өвөг дээдэс маань уудам монгол орныхоо уул толгод, даваа гүвээ, ус гол, тал хөндий, ургамал өвс, хөвч ойнхоо ил төрхийг төдийгүй, далд баялгийг нарийн

шинжих, танин мэдэх сайтар тунгаан бодож, түүний гоо үзэмж сүр жавхаа, шинж төрхийг нь тааруулан оноож өгсөн нэр нь хүртэл гайхалтай бөгөөд яруу билээ. Жишээ нь: Алтай таван богд, Хан хөхий, Мөнх хан, Галбын говь, Чандага гол гэх мэт сайхан нэр нь хүртэл Монгол хүн байгаль орчиндоо хандах хандлага, хайрлан хамгаалах үзэл бодлын илэрхийлэл юм.

4.5.4. Бүрэн дунд боловсролын нийгэм судлалын хичээл

4.5.4.A. ТХБ-д БДБ-ын нийгэм судлалын хичээлээр оруулах хувь нэмэр

БДБ-ын нийгэм судлал хичээл нь сурагчид нийгмийн бодит байдлыг шинжлэх ухаанчаар судлах арга барилтай болох, нийгмийн үнэт зүйлсийг эрхэмлэн хэрэгжүүлдэг, оролцоотой, хариуцлагатай, бүтээлч, бие дааж шийдвэр гаргах чадвартай иргэн болж төлөвшихөд хувь нэмэр оруулдаг. Тухайлбал,

- Нийгмийн бүтэц, харилцаа, соёл, эдийн засаг, улс төр, эрх зүй, олон улсын харилцаанд холбогдох тулгуур ойлголт, тэдгээрийн уялдаа холбоо, онолын гол үзэл баримтлалыг мэдэх, нийгэм, нийгмийн бүлэг, хувь хүнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга, аргачлалд суралцдаг.
- Нийгэмд болж буй үйл явдал, үзэгдлийг танин мэдэхдээ баримт, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, тоон болон чанарын мэдээлэл цуглуулж, шинжлэх зэрэг нийгмийн шинжлэх ухааны тодорхой аргыг ашиглаж, бие дааж дүгнэлт, шийдвэр гаргах чадварт суралцдаг.
- Нийгэм судлалын хичээлээр сурагчид шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, үүрэг хариуцлага, эрх зүйт ёс, хүнлэг ёс, ардчилал, энх тайван зэрэг нийгмийн үнэт зүйлсийг өөриймшүүлдэг.

Ахлах ангийн нийгэм судлалын хичээлээр тогтвортой хөгжилтэй холбогдох тодорхой асуудлыг танин мэдэх бололцоотой. Учир нь эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлт, тэгш байдал, шударга ёс, ядуурал өлсгөлөн зэрэгтэй холбогдох тогтвортой хөгжлийн зорилтууд нь нийгмийн ухааны хичээлийн үндсэн агуулга болж байдаг. Тухайлбал: "Нийгэм, нийгмийн харилцаа", "Эдийн засаг", "Хүний эрх", "Олон улсын харилцаа" зэрэг үндсэн агуулгын хүрээнд эдийн засгийн зохистой хэрэглээ, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, үүрэг хариуцлага, эрх зүйт ёс, хүнлэг ёс, ардчилал, энх тайван зэрэг ойлголтыг танин мэддэг. Сурагчид дээрх агуулгыг онолын мэдээлэл, судалгааны материал бусад эх сурвалжид тулгуурлан жишээ, тохиолдол шинжлэх, асуудал дэвшүүлэн шийдвэрлэх зэрэг аргаар судалдаг. Ингэхдээ асуудалд шүүмжлэлтэй хандах, урьдчилан тооцоолох, хамтран ажиллах, нийгмийн аливаа үзэгдлийг цогц уялдаа холбоонд авч үзэх, нотолгоо, үндэслэлгээнд тулгуурлан дүгнэлт хийх зэрэг ур чадвар, арга барилаа хөгжүүлж байдаг бөгөөд эдгээр нь нийгэм судлалын хичээлийн ТХБ-д оруулах хувь нэмэр их болохыг харуулж байна.

Хүснэгт 4.5.11. Суралцахуйн зорилт араа зүй, цогц чадамжийн интегерац (Бүрэн дунд боловсрол: Нийгэм судлал)

Цогц чадамж	Цогц чадамж		
	Код	Ундаслал, тайлбар	10
Аргыг зүй	7	Аргыг сонгосон үндэслэл, харилцааны урвалууд, суралцахуйн удирдамж, сурах бичиг, бусад	9
	8	Нийгмийн давхраажилтын шалтгааныг тайлбарлах социологийн онолын тайлбаруудыг өгүүлсэн эх сурвалж тухайлбал, Н.Скеллер, А.Ииденс, "Х.Г.Ундсамбуу нарын бүтээл", Монголын нийгмийн үндэслэл, үзэгдэл, үндэслэл, банкны өрхийн нийгэм-зүйн засаг, ядуурлын дүр төрх судалгааны талайгийн баримтууд, Нийгмийн давхраажилтын судалгааны баримтууд, зэргийг судлан өөрийн тиймхийн зарчмын үндсэн үндэслэл, тавьж, үндсэн үзэгдэл, хүчин зүйлийн нэг нь ядуурал болохыг жишээлэн тайлбарлах. Ядуурал нь нийгмийн зүл болохыг тодруулан авч үзэхдээ уялдаа холбоотой үндсэн үзэгдэл хувилбар даашуулх, мэтлэх зэрэг арга зүйгээр хичээл, үйл ажиллагаа зохион байгуулах. Сурь боловсролын НУ-ны хөтөлбөрөөр олон хүчин зүйлсээс болж нийгэм, хүмүүсийн дунд, ялангуяа, ядуурал үүсдэг. Чухал болохыг судалгааны холбоо хичээл, үйл ажиллагааг зохион байгуулах.	8
ТХБ	6	Агуулга: Ядуурал нь тэгш бус байдал, эрх мэдэл, ашиг сонирхлын ялгаатай байдалтай холбоотой ойлголт болохыг нийгмийн давхраажилтын өсөлөн ядуурал, тэгш бус байдал, үзэгдэл ядуурал нөлөөлөл нэг хүчин зүйл болохыг судлахдаа өнөөгийн тэгш бус хувиарилалт, эрх мэдэл, колоничлол, зөрчил мөргөлдөөн, байгалийн хүчин зүйлээс үлдсэн гамшиг, ур амьсгалын өөрчлөлтөөс бий болсон нөлөөлөл, хүрээлэл орчны дорлолт тооллол, түүнийг үнэмлэх хэмжээний дүгнэлтэй байдал зэрэг хүчин зүйлсийг мэддэг болно. Эцгээр хүчин зүйлсийн харилцаан хамаарлыг нийгэм, эдийн засаг, улс төр, хууль эрх зүй зэрэг олон талаас нь харж тогтоолох нь судалгаа. Тодруулан авч үзэх агуулга: Үндсэн хуулиар үндсэн хууль зөрчил, амьдралын эрхийн хөдөлгөөн, эрх зүйл аюул, эрхий амьдрах асарчын бодлол, байгалийн тэгшвэр алдагдахас хамгаалуулах зэрэг эрхийн хэрэгжилтийг өөрийн гэр бүлийн болон бусад хүмүүсийн амьжиргааны түүшин, нийгмийн хамгааллын байдалтай холбоон авч үзэх боломжтой. Мөн байгалийн хүчин зүйлээс үлдсэн үл амьсгалын өөрчлөлтөөс үзэгдсэн зорилго хөлбөж болохор байна. Сурь боловсролын НУ-ны хөтөлбөрийн хувь хүн ба нийгэм, хувь хүн ба эдийн засаг, нийгмийн удирдлага бүлэг сэдвүүдээр ядуу байгааас болоод тэгш бус хувиарилалт, эрхийн зөрчил үүсдэг, эдийн засгийн өсөлттэй ядуурал, амьжиргааг түвшин хэмээх ойлголт шууд хамааралтай.	7
	7	Бодит үйл ажиллагаандаа оролцох (компаниягийн, тамгалалт өдөр), Шинжлэх/судалгаа хийх (судалгааны төлөл, кэис судалгаа, загварлах), Бүтээл, шүүмжлэлтэй сэтгэх (Хэлэлцүүлэг,) Анхны хэргээрэй болгох (ирээдүйг үүлж, гурвалын төлөхөд шийдвэрлэх), Личный үрэлт, үрэлт, төлөхөд өрсөрсөн хэрэгсэх (хэрэгсэх)	9
Ангил	Х	XI	9
Цогц чадамж	1	Цогц чадамж	9
	2	Цогц чадамж	9

1-тоглоцот сэтгэлтээ: Нийгмийн өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлийг харилцан хайваралд нь авч үзэх, үзүүлэх нь олон хүчин зүйлээс болж үзэгдэл шалтгаалааг болохыг ойлгох аливаа тоглоцонд нь судлах сурах-үчдын чадварын хөгжилд хувь нэмэр оруулах. Ядуурал тэгш бус байдал, үзэгдэл, үндсэн үзэгдэл, хүчин зүйлийн нэг нь ядуурал болохыг жишээлэн тайлбарлах. Ядуурал нь нийгмийн зүл болохыг тодруулан авч үзэхдээ уялдаа холбоотой үндсэн үзэгдэл хувилбар даашуулх, мэтлэх зэрэг арга зүйгээр хичээл, үйл ажиллагаа зохион байгуулах. Сурь боловсролын НУ-ны хөтөлбөрөөр олон хүчин зүйлсээс болж нийгэм, хүмүүсийн дунд, ялангуяа, ядуурал үүсдэг. Чухал болохыг судалгааны холбоо хичээл, үйл ажиллагааг зохион байгуулах.

10.4.1.в, Болом-жигй эдийн за сгийн хувьд дээд зэргээр үр дүнтэй зарцуулахгүй байх зарчлаартай бo-лох	✓	ТХ308.НХ5. ТХ308.С01	<p>Агуулга: Эдийн засгийн өсөлт болон өөрийн амьдралын түвшин хоорондын хамаарал</p> <p>Тодруулан үзэх агуулга: Сурагч хувийн цогц чадамж, хүсэл сонирхолдоо тулгуурлан чадвар, ирээдүйн амьдралаа төлөвлөх чадвар болон ирээдүйн амьдралаа төлөвлөх чадвар суралцахад шаардлагатай зорилгоо тодорхойлох, өөрийн төсөв зохиох, хөтлөх, хуримтлал үзгэх, зарцуулалтад хяналт тавих, удаалар хэрэглэх бах, бизнесийн арга ухаанд суралцан иргэн байх чадваруудыг замших хүсэл эрмэлзлэлтэй мэдлэг, аргаар дүүжин давуу өрхийгөө амьжиргаа түвшингэй өндөрлөхөд сайжруулах боломжийг эрхэмлэхтэй холбоотойгоор эдийн засгийн боломж, өсөлт үр өгөөж, хэмнэлт, амьжиргаа түвшин зэрэг ойлголтуудыг ялган судална.</p>	✓	<p>*Хувийн амьдралд эдийн засгийн өсөлт, боломжийг ашиглах шийдэл, загваруудыг боловсруулах, эдийн засгийн өсөлтийн хөгжлийн үндэстэн өсөлдөд үзэж, үзүүлэх зарчмуудын зардал, хаммаарлын зүй тогтлыг харьяалан зөв хэрэглэж, өөрийн цогц чадамж, зорилго, эдийн засгийн төлөвлөгөө, боломж зэрэг хүчин зүгдл, тулгуурлан хэрэгжрүүлэх, тасархаа өөрчлөх, амьдралын түвшинг сайжруулахад боломжийг ашиглах бусдаас суралцах чадварын хөгжилд хувь нэмэр оруулна.</p>
3.Эдийн засаг	✓	ТХ309.ТМ5	<p>Агуулга: Төрөөс эдийн засгийг зохицуулах арга механизм</p> <p>Тодруулах агуулга: Сурагч төрөөс эдийн засгийг зохицуулах арга механизмудын нэг нь тогтвортой, уян хатан, дэд бүтцийн хөгжил болохыг ойлгох, дэд бүтцийг хөгжүүлэх нь яагаад улс орны хөгжилд чухал боломжжг жишээнд тулгуурлан тайлбарлахдаа тогтвортой, инноваци, уян хатан дэд бүтэц, үйлдвэр, өдөр болон үйлчилгээний салбарын чадвар, талаар төрийн үүрэг, оролцоо, цаашдын чиглэлд таллах мэдлэг, ойлголтыг ашиглана. Тогтвортой уян хатан, дэд бүтэц, инноваци зэрэг ойлголтуудыг ТХБ-ын мэдлэгээ ашиглан тайлбарлах, ойлгох.</p> <p>Тодруулбал, Тогтвортой-үрт цаг хугацааны туршид үргэлжлэх, уламжлан хадгалагдаж буюу тэрлэлтгүй үйлдвэр, өдөр болон үйлчилгээний салбарын чадвар, боломж бүс ихжилт түвшингээс үргэлжлэх үйл явц</p> <p>Төрийн үүрэг оролцоо гэд ойлголтод зөвхөн Засгийн газар гэж ойлгох боломжгүй сүм орон нутгийн засаг дарга, ИТХ-ын бодлого, шийдвэр, хийж буй үйл ажиллагаа, үүрэг, оролцоо гэдэг талаас нь судална. Дэд бүтцийн хөгжил нь адуурал, өслөглөн бууруулах, цааш хөгжлийн суурь үйлдвэр, үйлдвэр зэрэг ТХБ-ын бусад сэдвүүдтэй холбоотой судалдана.</p>	✓	<p>Сургалчд төрийн эдийн засгийг хөгжүүлэх арга замуудыг судлан шийдэх ямар асуудал байгааг илрүүлснээр асуудал шийдвэрлэх чадварг хувь эхнэр суралцаачдын зэрэгд аргачлан төрийн тийшээ тогтоосонд нь судлахын учир холбогдлыг уяваран ойлгоно.</p>

Монгол улсын эдийн засгийн хөгжилд харилцахад зориулж чиглэлийг бодит ижилж, статистик мэдээллийг ашиглан харилгах	✓	ТХ310.ТМ4. ТХ310.С05.	<p>Агуулга: Монгол улсын эдийн засгийн гадаад харилцааны хэлбэр</p> <p>Тодруулах агуулга: Төрөөс эдийн засгийг зохицуулах арга механизм болон дэмжжг байдга орон нутгийн үндэсний дэлхийн түвшний үйл явцыг судалж, мэдэх, ухаилбал, дэлхийн худалдааны системийг судалж, мэдэх, ойлгох.</p> <p>Улсын эдийн засгийн гадаад харилцааны зорилго, чиглэлтэй уялдуулан судлах, Монгол улс, олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, дэмжжг авч байдаг ач холбогдлыг мэдэрэх.</p>	✓	<p>1-Судалж буй агуулган хүрээнд мэдээлэлтэй ажиллах. Ойлогтоудын хоорондын хамаарлыг тогтооцот сэтгэгдлийг цогц чадамжаа хөгжүүлэх.</p>
1. Олон улсын харилцаа	✓	ТХ310.ТМ4. ТХ312.С08.	<p>Агуулга: Соёлын үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагууд</p> <p>Тодруулах агуулга: Соёлын үйлдвэрлэлийн ДНБ-д оруулж буй хувь нэмрийг тооцоолох, соёлын ямар бүтээгдэхүүн нь тогтвортой амьдралын хэв маяг ба тогтвортой үйлдвэрлэлд нөлөөллийг тодорхойлоход оруулж, тэдгэр үйлдвэрлэлд цаашдын хөгжлийн шаардлагыг үргэлжрээс өсдөг агуулгаар судлах. Соёлын олон янз шинжлэх замаар зах зээлд түүний оруулж байгаа хувь нэмрийг үнэлж дүгнэж чаддаг болох</p>	✓	<p>1-Соёлын үйлдвэрлэл нь ДНБ-д ямар хувь нэмэр оруулж байгааг судлахын үндэстэн өсөлдөд үйлдвэрлэлтэй харилцан хамааралтай ойлгож аливаа үзлийн харилцан хамаарлыг танин мэдэж ойлгож замаар тогтооцот сэтгэгдлийн цогц чадамжаа хөгжүүлэх.</p>
2 Соёл	✓	ТХ312.3У4. ТХ312.С010	<p>Агуулга: Монголчуудын соёл ба соёлын даяаршил хамгаалах бусдын соёлыг хүндэтгэх ач холбогдлыг ойлгож, ногоон эдийн засаг үйлдвэрлэл ба хэрэглээг нь хог харилд, хог уршиггүйгээр дахин ашигладаг аргаар хөгжүүлэхэд оруулж, тэдгэр үйлдвэрлэлд цаашдын хөгжлийн шаардлагыг үргэлжрээс өсдөг агуулгаар судлах. Соёлын олон янз шинжлэх ногоон өсөлт, хэргэлчлэний эрх ашигт ижилсэн экологид суурилсан зөв амьдралын зохиосот үйлдвэрийг хэрэглэх аргуудыг судалж зөв хэрэглээ ба хог уршиггүй үйлдвэрлэл бүтэц уриалан дуулах хүсэл эрмэлзлэлтэй болох</p>	✓	<p>5- Эх орон, дэлхийгээ хамгаалах нь иргэн бүрийн уургайгай холбоотой эргэцүүлэн бодж, дэлхийг эргэцүүлэн бодж, дэлхийг хөтөж, нөөцийг тооцоотой харилцан хамгаалж, оролцоонд оруулж, судалж, асуудлыг шийдвэрлэх замаар хамтран ажиллах чадвараа хөгжүүлнэ.</p>
3 Соёл	✓	ТХ312.3У5.	<p>Агуулга: Монголчуудын соёл ба соёлын даяаршил хамгаалах бусдын соёлыг хүндэтгэх ач холбогдлыг ойлгож, ногоон эдийн засаг үйлдвэрлэл ба хэрэглээг нь хог харилд, хог уршиггүйгээр дахин ашигладаг аргаар хөгжүүлэхэд оруулж, тэдгэр үйлдвэрлэлд цаашдын хөгжлийн шаардлагыг үргэлжрээс өсдөг агуулгаар судлах. Соёлын олон янз шинжлэх ногоон өсөлт, хэргэлчлэний эрх ашигт ижилсэн экологид суурилсан зөв амьдралын зохиосот үйлдвэрийг хэрэглэх аргуудыг судалж зөв хэрэглээ ба хог уршиггүй үйлдвэрлэл бүтэц уриалан дуулах хүсэл эрмэлзлэлтэй болох</p>	✓	<p>5- Эх орон, дэлхийгээ хамгаалах нь иргэн бүрийн уургайгай холбоотой эргэцүүлэн бодж, дэлхийг хөтөж, нөөцийг тооцоотой харилцан хамгаалж, оролцоонд оруулж, судалж, асуудлыг шийдвэрлэх замаар хамтран ажиллах чадвараа хөгжүүлнэ.</p>

4.5.4.Б. Нэгж хичээлийн жишээ

Хичээлийн сэдэв: “Монгол Улсын ДНБ-ний өсөлт ба ажил эрхлэлтийн хамаарал”

Анги:Х

Сэдэв сонгосон үндэслэл, багшид зориулсан тайлбар

Ахлах ангид нийгэм судлалын хичээлээр Үндэсний эдийн засгийн нэгдмэл үзүүлэлтийг авч үзэхдээ бид түүнд нөлөөлж буй хүчин зүйл тухайлан ажил эрхлэлтэй тэр болгон холболгүй тус тусад нь судалдаг. Харин улс орны эдийн засгийн хөгжлийг хэмждэг үндэсний үзүүлэлт болон ажил эрхлэлтийн талаар зэрэгцүүлэн судалснаар эдгээрийн уялдаа холбоо, хамаарлыг тогтоох боломжтой юм.

Иймээс бид сургалтын практикт байдаг агуулга тус бүрээр задлан судалдаг, залгамж холбоог төдийлөн гаргадаггүй дутагдалтай талыг даван туулж, эдийн засгийн өсөлт ба хүрээлэн буй орчин, ажил эрхлэлт зэргийн уялдаа холбоог судлахаар “Монгол Улсын ДНБ-ний өсөлт ба ажил эрхлэлтийн хамаарал” сэдэвт нэгж хичээлийн жишиг хөтөлбөрийг боловсрууллаа.

Энэхүү сэдэв нь ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилтын ТХ-ийн 8 дахь зорилгыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах бөгөөд энэхүү зорилгын хүрээнд санал болгосон “Эдийн засгийн өсөлтийн онолын таамаглал, загварууд, индикаторууд (Дотоодын нийт бүтээгдэхүүн-ДНБ, Үндэсний нийт орлого-ҮНО, Хүний хөгжлийн индекс-ХХИ)” гэсэн сэдэвтэй уялдаатай байна.

Сэдвийг судалснаар сурагчид эдийн засгийн үзэгдэл, үйл явдлыг цогцоор нь харилцан хамааралд нь танин мэдэх улмаар тогтвортой хөгжлийн тогтолцоот сэтгэлгээг хөгжүүлэх цогц чадамжтай болоход хувь нэмэр оруулж чадна. Энэхүү нэгж хичээлийн хөтөлбөрийг 8 цагийн хичээлээр хэрэгжүүлэх боломжтой.

Сургалтын хөтөлбөрийн агуулга (суралцахуйн зорилт)

- Үндэсний эдийн засгийн нэгдмэл үзүүлэлтүүд, тэдгээрийн мөн чанар, онцлог, хамаарлыг мэдэх

ТХЗ

Зохистой ажил ба эдийн засгийн өсөлт

ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт:

- Сурагч тасралтгүй, тусгай эрэлт хэрэгцээг хангахуйц (inclusive), тогтвортой эдийн засгийн өсөлт, орон тооны бүтээмжтэй ажил эрхлэлт, зохистой ажил тухайлбал, жендэрийн адил жигд оролцоо, эрх тэгш байдал зэрэг ухагдахуун, үзэл баримтлалыг ойлгох, эдийн засгийн альтернатив загвар, индикаторуудын талаар мэддэг болох

ТХЗ-д хүргэх санал болгож буй сэдэв:

- Эдийн засгийн өсөлтийн онолын таамаглал, загварууд, индикаторууд (Дотоодын нийт бүтээгдэхүүн-ДНБ, Үндэсний нийт орлого-ҮНО, Хүний хөгжлийн индекс-ХХИ)”

Арга зүйн сонголт:

- Бүтээлч сэтгэлгээний арга: асуудал дэвшүүлэн шийдвэрлэх, тохиолдол шинжлэх

Нэгж хичээлийн зорилго:

- Улс орны эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлын индикаторын нэг үзүүлэлт болох ДНБ ба бүтээмжит, зохистой ажил эрхлэлтийн хамаарлыг судлан ойлгоно.

Хичээлийн үндсэн агуулга:

Үйл ажиллагаа	Алхам	Хугацаа
Судлах агуулгын хүрээнд ярилцах	<ul style="list-style-type: none"> Мэдээллийг уншин ойлгох Өгөгдсөн асуултын дагуу ярилцах 	80 мин
Судалж буй агуулгын хүрээнд тулгуур ойлголт, мэдээлэлтэй ажиллах	<ul style="list-style-type: none"> Таван алхмын дагуу үйл ажиллагаа хийх 	80 мин
Асуудал дэвшүүлэн шийдвэрлэх арга зүйгээр судлах	<ul style="list-style-type: none"> Хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох нь “асуудлыг АДШ арга зүйгээр судлах 	160 мин

Үйл ажиллагаа 1. (Хугацаа 80 мин) Дараах мэдээллүүдийг уншаад өгөгдсөн асуултын дагуу ярилцан дүгнэлт гаргаарай.

Асуулт:


1. ДНБ өсөлт болон хүн амын ажил эрхлэлтийн хооронд ямар хамаарал байна вэ?
2. Эдийн засгийн өсөлт гэж юу вэ? Түүнд нөлөөлөх 1-2 хүчин зүйлийг нэрлэж, жишээ бичнэ үү.
3. Эдийн засгийн өсөлт:
 - тасралтгүй
 - тогтвортой
 - тусгай хэрэгцээг хангасан байна гэдэгт юу ойлгох вэ?
4. Манай улсын эдийн засгийн өсөлт, тасралтгүй, тогтвортой, тусгай хэрэгцээг хангаж чадаж буй эсэх талаарх Таны бодол ...?
5. 2017 оны эхний 9 дүгээр сарын байдлаар судалгаанд дурдсан аймгуудад ажилгүй иргэдийн тоо их байгааг ямар хүчин зүйлстэй холбон тайлбарлаж болох вэ?
6. ДНБ-ний өсөлт ба ажил эрхлэлтийн уялдаа, хамаарлыг судлах нь ямар ач холбогдолтой вэ?

Мэдээлэл 1: Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал 2017 оны эхний 4 сар

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2017 оны эхний улиралд 3063.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 122.7 (4.2%) тэрбум төгрөгөөр өслөө. Уг өсөлтөд аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг 28.3 (2.6%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 89.9 (6.3%) тэрбум төгрөг бүтээгдэхүүний цэвэр татвар 54.8 (18.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв. ДНБ 2017 оны эхний улиралд 5726.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 991.4 (20.9%) тэрбум төгрөгөөр өслөө. Улирлын нөлөөллийг арилган тооцооноор ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2017 оны эхний улиралд өмнөх улирлаас 0.5 хувиар өслөө. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр 2017 оны эхний улиралд 5555.1 тэрбум төгрөг, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 3146.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс оны үнээр 837.6 (17.8%) тэрбум төгрөгөөр өсөж, зэрэгцүүлэх үнээр 127.6 (4.2%) тэрбум төгрөгөөр өслөө.

Эх сурвалж: ҮСХ-ны мэдээлэл

Зураг. ДНБ-ний өсөлт, хувиар 2017.04 сарын байдлаар



Мэдээлэл 2: Монгол улсын бүртгэлтэй ажилгүй иргэдийн судалгаа

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд 2017 оны 4 дүгээр сарын эцэст 45.7 мянга болж, 33.0 (72.1%) мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 12.7 (27.9%) мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна. (2017 оны эхний 4 сарын байдлаар)

Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 60.1 хувийг 15-34 насны залуучууд эзэлж, энэ үзүүлэлт Өмнөговь, Говьсүмбэр, Орхон, Төв, Говь- Алтай, Ховд, Сэлэнгэ, Дундговь, Архангай, Дорнод, Сүхбаатар, Увс, Дорноговь аймагт улсын дунджаас 0.9-16.9 пунктээр илүү байна. (2017 оны эхний 9 дүгээр сарын байдлаар)

Эх сурвалж: УСХ-ны гаргасан Монгол улсын эдийн засгийн 2017 оны эхний 4 ба 9 дүгээр сарын тайлангаас.

Үйл ажиллагаа 2. (Хугацаа 80 мин) Тулгуур ойлголт, мэдээлэлтэй ажиллаарай.

Алхам 1: Дараах тодорхойлолт болон мэдээллийг уншаад ДНБ-ийг илэрхийлсэн гол санааг жагсаан бичиж, тус бүрт тайлбар хийнэ үү. Тухайлбал,

- Санаа 1. Улсын хэмжээгээр
- Санаа 2.
- Санаа 3.

Тухайн улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, эцсийн бараа, үйлчилгээний зах зээлийн үнийн дүнг ДНБ гэнэ.

Мэдээлэл: Ихэнх бүтээгдэхүүн эцсийн буюу бэлэн бүтээгдэхүүн болж зах зээлд гартлаа үйлдвэрлэлийн хэд хэдэн шат дамждаг. Эцсийн бүтээгдэхүүнд (талх) үйлдвэрлэлийн шат дамжлага бүрт шинээр бий болсон өртгийг (үр тариа, гурил гэх мэт) хамтдаа тооцогддог учраас ДНБ-д зардлыг давхардуулан тооцохгүйн тулд эсвэл эцсийн бүтээгдэхүүний үнийг үйлдвэрлэлийн шат дамжлага бүрт шинээр бий болсон өртгийг нэмж тооцно. Сүүдрийн эдийн засаг гэсэн ойлголтод эдийн засгийн салбар дахь хуулиас гадуур болон нарийн үнэлж чаддаггүй, заримыг ерөөс үнэлэх боломжгүй үйл ажиллагааг оруулж болох бөгөөд эдгээрийг ДНБ-д тооцох боломжгүй.

- Эдийн засгийн өсөлтийг нэлээд өргөн хэрэглэгдэж буй дараах 2 тодорхойлолтоор хэмждэг.
- Ашиглагдаж байгаа үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн тоо хэмжээг нэмэгдүүлсний буюу техник технологийг боловсронгуй болгосны үр дүнд ҮНБ-ний хэмжээнд гарах бодит өөрчлөлтөөр
- Нэг хүн амд ноогдох бодит орлогын хэмжээ буюу ҮНБ-ний бодит хэмжээ өсөх үйл явцаар.

Алхам 2: Уншсан мэдээллээ ашиглан дараах тохиолдлыг шинжлээрэй.

Сурагч Б-ийнх ам бүл олуулаа. Аав нь авто машины засварын газар байгуулж төлбөртэй засвар хийж мөнгө олдог. Засварын газар 5 хүн ажилладаг. Харин ээж нь төрийн байгууллагад ажилладаг бөгөөд амралтын өдрүүдэд хоол ундаа бэлтгэж, хүүхдүүд нь хувцсаа угаадаг. Эднийх хувийн эзэмшлийн газартаа хүнсний ногоо тариалж, зах зээлийн үнээр зарж борлуулдаг. Хотод байдаг оюутан ах нь эцэг, эхээсээ мөнгө авч сургалтын төлбөрөө төлжээ. Мөн эднийх “Говь ХК”- ийн 100 ширхэг хувьцаа худалдан авсан байна.

Шинжлэх асуулт:

- Тохиолдлыг эдийн засгийн ямар ямар ойлголтоор тайлбарлаж болох вэ?
- Авто машины засварын газар байгуулан ажиллуулж байгаа нь эцсийн буюу бэлэн бүтээгдэхүүнд тооцогдох уу?
- Сурагч Б-ийн гэр бүлийнхэн ДНБ-ний өсөлтөд хувь нэмэр оруулж чадаж байна уу?

Алхам 3: Дараах мэдээллийг уншаад Иш аргаар өөрийн санаагаа нөхөж бичээрэй.

Хөдөлмөрийн зах зээл нь байнга хувьсан өөрчлөгдөж байдаг. Тухайлбал, нэг компани үүсгэн байгуулагдаж шинээр ажилтан нэмж авч байхад, өөр компани цомхотгол хийж ажилгүй болох, тухайн ажилчин нь тэтгэврийн насанд хүрэх, шилжих хөдөлгөөнөөс болж ажлаа солих гэх мэт нь хөдөлмөрийн зах зээлийн байдалд нөлөөлдөг. Энэ нь ДНБ-ийг тооцох үзүүлэлтэд шууд нөлөөлдөг.

Боловсролын түвшин ба ажил эрхлэлт

1	Боловсролгүй	1.3
2	Бага	2.1
3	Суурь	6.0
4	Бүрэн дунд	44.7
5	Тусгай мэргэжлийн дунд	6.0
6	Техникийн болон мэргэжлийн	6.7
7	Дипломын дээд болон бакалаврын	31.5
8	Магистр, доктор	1.7

Эх сурвалж: <http://www.mlsp.gov.mn>

Үйлдвэрлэлийн тоо хэмжээ хязгаарлагдмал байдаг тул хүн амын тоо өсөхийн хирээр нөөцийн хэмжээ багасч байдаг. Япон, Солонгос зэрэг улс байгалийн баялаг багатай ч эдийн засгийн хурдацтай өсөлтөөрөө дэлхийд тэргүүлж байна. Эдгээр оронд өндөр боловсролтой, хөдөлмөрлөх хүсэл эрмэлзэлтэй хүмүүс олон байдаг бөгөөд мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд улсаас хөрөнгө оруулалт их хийдэг. Иймээс:

Миний бодлоор:

.....

Миний уншиж судалснаар:

.....

зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь чухал гэж би бодож байна.

Үйл ажиллагаа 3. (Хугацаа 160 мин) Дараах асуудлын хүрээнд:

- Мэдээлэл цуглуулан судалж,
- Асуудал дэвшүүлэн шийдвэрлээрэй.
- Асуудал шийдвэрлэх аргын тайлбар: Энэ аргын мөн чанарыг танин мэдэхэд асуудал гэсэн ухагдахууныг тодруулан ойлгох нь чухал. Асуудал бол бэлэн байгаа мэдлэгээ ашиглаад шууд хариулж чадахгүй, ямар нэгэн хэмжээний эрэл, хайгуул, судалгаа, шинжилгээ хийхийг шаардсан хүмүүсийн амьдралд байдаг бэлэн асуулт, баримт юм. Асуудал нь сурагчдын амьдралын туршлага, бодит хэрэгцээнээс урган гарсан байх ёстой.
- Асуудал дэвшүүлэн шийдвэрлэх аргын үе шатыг тодруулан харуулбал:
 - Тулгамдаж буй асуудлыг тодруулах, тэдгээрийг эрэмбэлэх;
 - Тэдгээр асуудлаас хамгийн түрүүнд шийдвэрлэж болох нэг асуудлыг сонгох, олон өнцгөөс харж, өөрийн хувилбаруудыг дэвшүүлэх, шийдлийг ярилцах;
 - Асуудлыг судлах аргаа сонгох;
 - Сонгосон аргаараа асуудлаа судлах;
 - Судалсан үр дүнгээ танилцуулах.¹³¹

Асуудал: “Хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүйгээр эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох боломжтой эсэх”

Энэхүү хичээлээр дараах 2 үйл ажиллагааг төлөвлөсний дагуу хийнэ.

- Үйл ажиллагаа 1: Судлах асуудлын талаар ярилцах, ойлголтоо нэгтгэх, тухайн асуудалтай шууд хамаатай асуудлыг дэвшүүлэх - 90 мин
- Үйл ажиллагаа 2: Сонгосон асуудлыг судлах - 90 мин

Төлөвлөсөн үйл ажиллагаа бүр зорилго, алхамчлалын дагуу боловсруулагдсан бөгөөд багш та арга зүйн санааг дэлгэрүүлэн хичээлээ зохион байгуулах боломжтой. Гол санаа нь эдийн засаг өсөлт түүнээс ДНБ-ний ба ажил эрхлэлт, хүрээлэн буй орчны уялдаа холбоо, хамаарлыг шинжилж, байгальд ээлтэй, хариуцлагатай хэрэглээг эрхэмлэхийн чухлыг сурагчид ойлгон ухамсарлахад оршино.

Хичээлийн төлөвлөлт**Багийн анхаарах зүйл**

- Сурагчдыг багт хуваахдаа дуртай өнгө, төрсөн улирал зэргийг харгалзах нь тэдний сонирхол ойролцоо байх магадлал өндөртэй байдгийг тооцох;
- Дадлага ажлын үед хэрэглэх зааварчилгааны дагуу ажиллахад сурагчдыг чиглүүлэх;
- Багийн ажилд хүн бүрийн оролцоо жигд байхад анхаарах, зөвлөх;
- Төлөвлөсөн цагийг баримтлан ажиллах;
- Сургалтын хэрэглэгдэхүүний бэлтгэлээ сайтар хангах;

Үйл ажиллагаа 1: Судлах асуудлын дагуу санал солилцох, ойлголтоо нэгтгэх, шууд хамаатай асуудлыг дэвшүүлэх 90 мин


Зорилго:	Асуудал гэж юу вэ? “Хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох нь” асуудлын талаар ойлголтоо нэгтгэх	
Алхам	Үйл ажиллагааны дараалал	Хэрэглэгдэхүүн
Алхам 1 60 мин	<ul style="list-style-type: none"> - Хүн бүр нэг цаасан дээр судалж асуудалтай шууд хамаатай нэг асуудлыг бичнэ. Жишээ нь, “эдийн засаг өсөж байхад ажилгүйдэл буурахгүй байна”, “шинэ үйлдвэр, аж ахуйн газрууд бий болж байхад бидний амьсгалж буй агаар бохирдож, уух усыг багасгаж байна” гэх мэт - “Байцайны хальсаа задлан уншиж, ярилцана. - Хүн бүрийн бичсэнийг жагсаан бичиж багцална. Тухайлбал, нийгмийн шинжтэй, байгал орчны шинжтэй, эдийн засгийн шинжтэй асуудлаар нь ялган ангилна. <p>Байцай хальслах аргын тайлбар: Хэлэлцэж байгаа асуудлын хүрээнд хүн бүрийн саналыг авах, саналаа солилцох боломжийг бүрдүүлдэг идэвхтэй сургалтын аргын нэг юм.</p>	<p>A4 цаасыг дөрөв хувааж нэг хэсэгтэй нь тэнцэх хэмжээний жижиг цаас хүн бүрийн тоогоор</p> <p>Дадлага ажлын цаас, маркер багийн тоогоор</p> <p>НУ -Ү1 сурах бичгийн 85 дахь тал</p>
Алхам 2 30 мин	<ul style="list-style-type: none"> - Баг тус бүр дээр ангилсан асуудлаас нэгийг судлахаар сонгоно. - Сонгосон асуудлын хүрээнд цуглуулах мэдээллийн жагсаалт болон судлах төлөвлөгөө боловсруулна. 	Хавсралтад байгаа Зураг 1

Үйл ажиллагаа 2: Сонгосон асуудлаа багаараа хамтран судлах, үр дүнг танилцуулах - 90 мин

Зорилго:	Эдийн засаг өсөлт, ажил эрхлэлт, хүрээлэн буй орчны уялдаа, хамаарлыг шинжлэх, асуудал дэвшүүлэн шийдвэрлэх аргад суралцах	
Алхам	Үйл ажиллагааны дараалал	Хэрэглэгдэхүүн
Алхам 1 20 мин	<p>Хүн бүр асуудлыг тодорхойлох дараах 2 аргын тайлбарыг уншиж судлаад, багаараа ярилцаж аль нэг аргыг сонгоно.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Асуудлын мод үүсгэх - PESTIE шинжилгээ хийх <p>Арга 1: “Асуудлын мод” арга: Энэ арга нь асуудлыг үүсгэж буй нөхцөл, үр нөлөө, бүх талын хүчин зүйлийг тодорхойлон авч үзэх боломжийг олгодог бүтээлч сэтгэлгээний аргын нэг юм.</p> <p>Асуудлыг судлах аргаа судлан сонгох</p> <p>Ажиллах аргачлал: Дэлгэцийн том цаасан дээр ургаж байгаа мод зурна. Модны их биед уур амьсгалын өөрчлөлт гэж бичнэ. Энэ асуудалд хүргэж буй хүчин зүйлсийг модны үндэс хэсэгт, асуудлаас үүсэх үр дагаврыг модны мөчрөөр төлөөлүүлэн зурна. (Зураг 1)</p> <p>Арга 2: “PESTIE шинжилгээ хийх” арга: Энэ арга нь асуулт ашиглан судлах асуудлыг тодорхойлдог арга юм. PESTIE шинжилгээ нь зургаан бүлэг асуултаар асуудлыг бүрэн ойлгоход тусалдаг. Ашиглах асуултуудыг “Уур амьсгалын өөрчлөлт, нөлөөлөл” жишээгээр харуулбал:</p>	<p>Аргуудын тайлбар (асуудлын мод, PESTIE шинжилгээ)</p> <p>Зураг 1: Асуудлын модны зураг</p>

	<ol style="list-style-type: none"> Улс төрийн: Уур амьсгалын өөрчлөлтийн талаар орон нутгийн захиргаа болон үндэсний засгийн газар анхаарлаа хандуулж байна уу? Эдийн засгийн: Ган гачиг үер зэрэг цаг агаарын хүнд нөхцөлүүд танай орон нутагт хохирол учруулсан уу? Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх санхүүжилт байгаа юу? Нийгмийн: Асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн хүмүүс хамтран ажилласан уу? Технологийн: Танай орон нутгийн усны, цахилгааны эх үүсвэр найдвартай юу? Хуулийн: Танай улс Киотогийн тунхаглалд нэгдсэн үү? Хүрээлэн буй орчны: Хууль бусаар мод бэлтгэх, байгалийн нөөцийн зохистой хэрэглээ ямар байна? 	
Алхам 2 40 мин	Сонгосон аргын дагуу асуудлыг судлахдаа тухайн асуудлын нөлөөлөл, шалтгаан, үр дагавар, шийдэх арга замыг тодорхойлно.	Дадлага ажлын цаас, маркер багийн тоогоор
Асуудлыг судлах	Асуудлыг судалсан үр дүнгээ дараах хувилбараас сонгон илэрхийлээрэй. <ul style="list-style-type: none"> - Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах - Мөрийн хөтөлбөр боловсруулах - Орон нутгийн удирдлагуудад захидал бичих - Ханын илтгэл бэлтгэх 	Ашиглах материал 1: Захидал бичих загвар Ашиглах материал 2: Үйл ажиллагааны төлөвлөгөөний загвар Ашиглах материал 3: Мөрийн хөтөлбөрийн загвар
Алхам 3 30 мин Судалсан үр дүнгээ танилцуулах	Галарей үзэх аргаар багууд судалсан үр дүнгээ танилцуулна. Галарей үзэх аргын тайлбар: Сурагчид хийсэн бүтээлээ богино хугацаанд харилцан мэдээлэх, шинэ санаа олж авах зорилготой бүтээлч сэтгэлгээний арга.	

Хавсралт

Зураг 1: Асуудлын мод	Ашиглах материал 1: Захидал бичих загвар
	<p>Захидлын хэлбэр:</p> <p>Хэнээс</p> <p>Хэнд</p> <p>Юуны учир</p> <p>Захидлын агуулга :</p> <p>Захидал бичсэн: Овог, нэр,</p> <p>Оршин суугаа газрын хаяг</p>

Ашиглах материал 2: Үйл ажиллагааны төлөвлөгөөний загвар

Үйл ажиллагааны нэр:

Зорилго:

Хүрэх үр дүн:

Хүрэх үр дүн	№	Төлөвлөсөн үйл ажиллагаа	Хугацаа	Хэн хариуцах	Хамрах хүрээ	Биелэлт, үр дүн
	1					
	2					
	3					
	4					
	5					
	6					

Ашиглах материал 3: Мөрийн хөтөлбөрийн загвар*Мөрийн хөтөлбөрийн бүтэц, агуулгын жишээ:*

Бүтэц	Агуулгын тайлбар
Үндэслэл	Яагаад энэ асуудал чухал гэж үзэж мөрийн хөтөлбөр боловсруулсан, хэрэгжих үндэслэл нь юу вэ?
Үндсэн хэсэг	Хэрэгжих боломж, эрсдэл гарвал хэрхэн шийдэх талаар
	Тухайн асуудлаар одоогийн ба өнгөрсөн түүхийг нэгтгэн дүгнэсэн байдал
	Нэр дэвшигчээс хэрэгжүүлэх үндсэн зорилт, үйл ажиллагааны ерөнхий чиглэл (хэрэгжүүлэх үндсэн арга)
Үр дүн	Мөрийн хөтөлбөрийн онцлог, давуу тал
	Мөрийн хөтөлбөр хэрэгжсэнээр ямар ач холбогдолтой вэ?, хэрэгжилтэд үнэлгээ хийж үр дүнг хэрхэн тооцох талаар